



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ДАРГА ГОМБОЖАВЫН  
ЗАНДАНШАТАР ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08.  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2023.06.23 № 3Г-1/103  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

Хуулийн төсөл өргөн  
мэдүүлэх тухай

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгөхийг хүсье.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

ЛОЮУН-ЭРДЭНЭ

000224000013



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

додг. 06.22 № ХЭТ/1524  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх  
хугацааг товлох тухай

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Хавсралт<sup>166</sup>... хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА




Д.АМАРБАЯСГАЛАН

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 27 дугаар тэмдэглэлд:

"I.ХЭЛЭЛЦСЭН нь: Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналыг тусган Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2023.06.22 № 1/3490

танай 2023.06.21-ны № 01/1118-Т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН  
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан хууль тогтоомжийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151603150

А5 Файл.2023



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn  
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.06.22 № 01/4678

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД  
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН  
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА**

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн,

**Б.ЖАВХЛАН**

**9761001407**



## ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2-т “Эдийн засгийн аюулгүй байдал”-ын хүрээнд “Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтэц бүхий, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, эдийн засгийн бие даасан байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх бодлого баримтална” гэж тусгасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно”, уг зорилгыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “1.гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна”, мөн “Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна”, мөн ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.3.12-т “Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зохицуулалтын орчныг сайжруулна” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.2.3-т “гадаад хөрөнгө

оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ”, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.5.3-т “Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ” гэж заасан байна.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 5 дугаар хавсралтад Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан.

## **1.2.Практик шаардлага**

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2015 оноос хойш гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалаас шууд хамаарч байна. Түүнчлэн дотоодын нийт бүтээгдэхүүний 75 орчим хувийг хувийн хэвшил бүрдүүлдэг ба хөдөө аж ахуй, боловсруулах, барилга, худалдаа зэрэг салбарын үйлдвэрлэлийг хувийн хэвшил дангаар бүрдүүлж байна.

Монгол Улсад 1990-2022 оны байдлаар нийт 39.7 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 72 хувь нь уул уурхайн олборлолт 11 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбарууд нийлээд 17 хувийг эзэлж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байна. Оюутолгой төслийн уул уурхайн олборлолт, бүтээн байгуулалттай холбоотойгоор Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 оноос эрс нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын 50 орчим хувийг “Оюутолгой” ХХК дангаар бүрдүүлж байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлд нийт 246.8 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 9,350 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 1990-2023 онд нийт 14,836 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 5486 аж ахуйн нэгж татан буугдсан байна. Эдгээр аж ахуйн нэгжийн 33 хувь нь 2010-2022 онд татан буугдсан байна.

Сүүлийн 3 жилийн дунджаар аж ахуйн нэгжийн төлсөн нийт татварын 23 хувийг буюу 2.63 их наяд төгрөгийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүрдүүлсэн бол 2022 онд 16 хувь буюу 2.4 их наяд болж буурсан байна.

Түүнчлэн аж ахуйн нэгжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрээр ялгаварласан, үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хязгаарласан зохицуулалт болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, хүсэлтээ шийдвэрлүүлэх

хугацаа, төлбөр хураамжийг ялгамжтай тогтоосноос шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хараат болон охин компани, компанийн нэгдлийг байгуулж байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бодит үр өгөөжийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлоход хүндрэлтэй байна.

Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулагчийг зах зээлийн судалгаа, мэдээллээр хангах замаар хөрөнгө оруулалт татах, шинээр хөрөнгө оруулалт орж ирэх үеийн бүртгэл, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааг сайжруулж, хөрөнгө оруулалтын үе шатад тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаа шуурхай явуулах нөхцөлөөр хангах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргаан шийдвэрлүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

Улсын Их Хурлаас 2013 онд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталснаас хойш нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд дийлэнх өөрчлөлт нь бусад хуулийг дагалдаж нэмэлт, өөрчлөлт орсон тул хуулиар зохицуулж буй зарим төрлийн харилцааг тодруулах, хууль хоорондын уялдааг сайжруулах хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Иймд гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

### **Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төслийн зорилго нь Монгол Улсын эдийн засгийн хөгжлийг хөрөнгө оруулалтад түшиглэн дэмжих, Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын баталгааг тогтоох, хөрөнгө оруулагчид татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлох, хөрөнгө оруулалтыг хадгалах, хамгаалах талаар төрийн байгууллагын эрх, үүргийг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулах юм.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд зарчмын шинжтэй нэмэлт, өөрчлөлтүүд хийгдэж, нийт заалтын 50-аас дээш хувьд нь нэмэлт, өөрчлөлт орохоор байх тул

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.2-т тус тус заасны дагуу хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хөрөнгө оруулагчийн хууль ёсны баталгааг хангах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахтай холбоотой дараах зохицуулалтыг шинээр тусгана. Үүнд:

-Хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл гомдол гаргах эрхийг баталгаажуулж, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт оруулж олон улсын сайн туршлагыг нэвтрүүлнэ.

-Хуулийн төсөлд шинээр хөрөнгө оруулалтын талаарх Засгийн газар, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Дипломат төлөөлөгчийн газрын эрх үүргийг тусган төрийн байгууллагын хоорондын нэгдсэн уялдааг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

-Одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгохоор тусгагдсан бол хуулийн төсөлд хөрөнгө оруулалтаа хийж буй эсэхэд хяналт тавих зохицуулалтыг тусгаж, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа хэвийн явуулахад зөвлөмж, чиглэл өгөх зохицуулалтыг тусгана.

-Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулахаар сонирхож буй аж ахуйн нэгжүүдэд зориулсан хөрөнгө оруулалтын орчин, хууль, эрх зүйн сурталчилгаа, мэдээллийг нэг цонхоор хүргэх, хөрөнгө оруулалт татах төслүүдийг бэлтгэх, бэхжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчлан тусгаж, хөрөнгө оруулагчдад зөвлөх, дэмжих болон бусад холбогдох үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

-Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэр томъёоны тодорхойлолтыг оновчтой, ойлгомжтой болгож, хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг, нарийвчлан зохицуулалт хийх шаардлагатай хэм хэмжээний актын батлах эрхийг тодорхойлж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ.

-Хөрөнгө оруулагчдыг дэмжих, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгана.

**Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал**

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгэм, хууль зүйн хувьд дараах үр дүн гарна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөл бүрдэнэ.

2. Эдийн засгийг төрөлжүүлж, үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад худалдааг өргөжүүлэх, дэвшилтэд техник технологи, ноу-хау нэвтэрснээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжирч, инновацыг дэмжих замаар Монгол Улсын өрсөлдөх чадвар дээшилнэ.

3. Тогтвортой ажлын байр бий болж, шинэ мэдлэг, ур чадварыг эзэмшүүлж, ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, дундаж цалингийн хэмжээ болон өрхийн орлого нэмэгдэнэ.

4. Хөрөнгө оруулалтад тулгуурлан дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалт нэмэгдэж, тээвэр, логистикийн зардал буурах, ханган нийлүүлэлтийн сүлжээний үр ашиг нэмэгдэх, улмаар шинээр хөрөнгө оруулалт татах боломжийг бий болгоно.

5. Хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр татварын бааз суурь тэлж, төсвийн орлого нэмэгдэн улс болон орон нутгийн хөгжлийг хурдасгаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

**Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Барилгын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль болон “Хуулийн хэрэгжилт хангуулах тухай” Улсын Их хурлын тогтоолын төслийг төслийг тус тус боловсруулна.

## ТАНИЛЦУУЛГА

### *Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл*

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна” гэж заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2-т “Эдийн засгийн аюулгүй байдал”-ын хүрээнд “Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтэц бүхий, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхыг бүрдүүлж, эдийн засгийн бие даасан байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх бодлого баримтална” гэж тусгасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно”, уг зорилгыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “1.гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна”, мөн “Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна”, мөн ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.3.12-т “Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зохицуулалтын орчныг сайжруулна” гэж тус тус заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.2.3-т “гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ”, Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.5.3-т “Гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг тууштай хамгаалж, дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбар, мега төслүүдэд гадаадын хөрөнгө оруулалт татах, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж авахад дэмжлэг үзүүлнэ” гэж заасан байна.

Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 5 дугаар хавсралтад Хөрөнгө оруулалтын тухай хуулийн

шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ гэж тус тус заасны дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн найруулах хууль зүйн хэрэгцээ шаардлага бий болсон.

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2015 оноос хойш гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалаас шууд хамаарч байна. Түүнчлэн дотоодын нийт бүтээгдэхүүний 75 орчим хувийг хувийн хэвшил бүрдүүлдэг ба хөдөө аж ахуй, боловсруулах, барилга, худалдаа зэрэг салбарын үйлдвэрлэлийг хувийн хэвшил дангаар бүрдүүлж байна.

Монгол Улсад 1990-2023 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 41.1 тэрбум ам.долларын гадаадын хөрөнгө оруулалт орж ирснээс 73 хувь нь уул уурхайн олборлолт 11 хувь нь худалдаа, үйлчилгээний салбарт хийгдсэн бол бусад салбарууд нийлээд 16 хувийг эзэлж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн нэг салбарт харьцангуй ихээр төвлөрч байна. Оюутолгой төслийн уул уурхайн олборлолт, бүтээн байгуулалттай холбоотойгоор Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 оноос эрс нэмэгдэж, сүүлийн 10 жилийн дунджаар гадаадын шууд хөрөнгө оруулалтын 42 хувийг "Оюутолгой" ХХК дангаар бүрдүүлж байна.

Монгол Улсын хэмжээнд 2023 оны 1 дүгээр улирлын байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлд нийт 246.8 мянган аж ахуйн нэгж бүртгэлтэй байгаагаас гадаадын хөрөнгө оруулалттай 9,350 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлд 1990-2023 онд нийт 14,836 гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүртгэгдсэнээс 5486 аж ахуйн нэгж татан буугдсан байна. Эдгээр аж ахуйн нэгжийн 33 хувь нь 2010-2022 онд татан буугдсан байна.

Сүүлийн 3 жилийн дунджаар аж ахуйн нэгжийн төлсөн нийт татварын 23 хувийг буюу 2.63 их наяд төгрөгийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүрдүүлсэн бол 2022 онд 16 хувь буюу 2.4 их наяд болж буурсан байна.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулагчийг зах зээлийн судалгаа, мэдээллээр хангах замаар хөрөнгө оруулалт татах, шинээр хөрөнгө оруулалт орж ирэх үеийн бүртгэл, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагааг сайжруулж, хөрөнгө оруулалтын үе шатад тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаа шуурхай явуулах нөхцөлөөр хангах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргаан шийдвэрлүүлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь эдийн засгийн бүх салбар, үйл ажиллагааг хамарсан өргөн хүрээний асуудал тул хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр төрийн байгууллагын уялдаа холбоог хангах шаардлагатай байна.

Улсын Их Хурлаас 2013 онд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг баталснаас хойш нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд дийлэнх өөрчлөлт нь бусад хуулийг дагалдаж нэмэлт, өөрчлөлт орсон тул хуулиар зохицуулж буй зарим төрлийн харилцааг тодруулах, хууль хоорондын уялдааг сайжруулах хэрэгцээ, шаардлага үүсээд байна.

Иймд дээр дурдсан нөхцөл шаардлагад үндэслэн гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмжих, хөрөнгө оруулалтын орчинд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасны дагуу Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл буюу 65 хоногийн хугацаанд хуулийн төслийг монгол, англи хэлээр цахим хуудсанд байршуулж, олон нийтийн саналыг авсан. Мөн олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын 120 гаруй байгууллагын 250 орчим төлөөллийг оролцуулан хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг 2 удаа, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоодын төлөөллүүдтэй 10 гаруй цуврал уулзалтуудыг зохион байгуулан олон нийтийн оролцоог хангаж ажиллалаа.

Хуулийн төсөлд олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс нийт 695 саналыг хүлээн авлаа. Нийт ирүүлсэн 695 саналын 60 хувийг хуулийн төсөлд тусгаж, 20 хувийг тусгаагүй, 20 хувь нь сэтгэгдэл байсан бөгөөд санал ирүүлсэн байгууллагуудад хуулийн төсөлд хэрхэн тусгасан талаар хариу мэдэгдэж ажилласан.

Хуулийн төслийг хөрөнгө оруулалтын орчны тогтвортой байдлыг хангах, хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын баталгааг сайжруулах, хөрөнгө оруулагчдад үзүүлэх дэмжлэг, төрийн үйлчилгээг сайжруулж, хялбаршуулахыг зорьж дараах 10 зарчмын асуудлуудыг шинээр тусган боловсруулаад байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хориглосон, хязгаарласан зарим зохицуулалтуудыг арилгасан.
- Хөрөнгө оруулагчдад үзүүлэх баталгааг олон улсын сайн туршлагад нийцүүлэн сайжруулсан.
- Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл буюу гомдол шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлж, гомдлыг шийдвэрлэх асуудлыг нарийвчлан тусгасан.
- Хөрөнгө оруулагч, төр хооронд үүссэн хөрөнгө оруулалтын маргааныг олон улсын арбитрын журмаар шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулсан.

- Хөрөнгө оруулалтыг хамгаалах, дэмжих үүргийг төрийн бүх байгууллагуудын чиг үүрэг болгон тодорхойлж тусгасан.
- Татварын урамшууллын асуудлыг татварын хуулиар зохицуулах өөрчлөлт оруулсан.
- Төрөөс хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын давхардлыг арилгах зохицуулалтыг оруулсан.
- Тогтворжуулах гэрчилгээ олгох шалгуурыг хялбаршуулж, цахимаар олгох нөхцөлийг бүрдүүлсэн.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар эдийн засаг, нийгэм, хууль зүйн хувьд дараах үр дүн гарна. Үүнд:

1. Хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэж, гадаадын шууд хөрөнгө оруулалт татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, хөрөнгийн урсгалыг нэмэгдүүлэх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах нөхцөл бүрдэнэ.

2. Эдийн засгийг төрөлжүүлж, үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, гадаад худалдааг өргөжүүлэх, дэвшилтэд техник технологи, ноу-хау нэвтэрснээр бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжирч, инновацийг дэмжих замаар Монгол Улсын өрсөлдөх чадвар дээшилнэ.

3. Тогтвортой ажлын байр бий болж, шинэ мэдлэг, ур чадварыг эзэмшүүлж, ажиллах хүчний оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, дундаж цалингийн хэмжээ болон өрхийн орлого нэмэгдэнэ.

4. Хөрөнгө оруулалтад тулгуурлан дэд бүтцийн салбарын бүтээн байгуулалт нэмэгдэж, тээвэр, логистикийн зардал буурах, ханган нийлүүлэлтийн сүлжээний үр ашиг нэмэгдэх, улмаар шинээр хөрөнгө оруулалт татах боломжийг бий болгоно.

5. Хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр татварын бааз суурь тэлж, төсвийн орлого нэмэгдэн улс болон орон нутгийн хөгжлийг хурдасгаж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

Хуулийн төсөл нь үндсэн 7 бүлэг, 33 зүйлээс бүрдэх бөгөөд хуулийн төслийг дагалдаж Хууль хүчингүй болсонд тооцох тухай, “Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл болон холбогдох бусад 18 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь боловсруулсан.

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 27 дугаар хуралдаанаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон болно.

## ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хуулийн төслийг Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Хуулийн тогтоомжийн тухай хуулийн шаардлагад нийцүүлсэн боловсруулж, олон нийтээс ирүүлсэн санал, Засгийн газрын гишүүдийн саналыг тусган 7 бүлэг 33 зүйлтэйгээр боловсруулсан.

№	Бүлэг	Зүйл	Танилцуулга
1	Нийтлэг үндэслэл	<p>1 дүгээр зүйл.Хуулийн зорилт</p> <p>2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж</p> <p>3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ</p> <p>4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт</p> <p>5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа</p>	<p>1.Хуулийн төслийн зорилтыг НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурлын хөрөнгө оруулалтын орчны мэдээллийн санд буй 124 оны хөрөнгө оруулалтын хуулийн зорилго, олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмж, хуулийн төсөлд ирүүлсэн саналд үндэслэн хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулагчийн эрх үүргийг тодорхойлж өөрчлөн найруулсан.</p> <p>2.Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь бүх төрлийн салбарт хамаарах тул хуулийн нэрийг тоочих нь орхигдуулах эрсдэлтэй. Иймд, хууль тогтоомж хэсгийг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуульд нийцүүлсэн бусад хууль тогтоомж гэж тодорхойлсон.</p> <p>3.Хуулийн төслийн үйлчлэх хүрээг Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагад нийцүүлэн хамааралгүй зохицуулалтыг хасаж, хуулийн төсөлд тусгасан зохицуулалтуудтай уялдуулсан.</p> <p>4.Хуулийн төслийн нэр томъёонд дараах зарчмын нэмэлт, өөрчлөлтийг бий болгосон. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Гадаадын хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд тавигдах шаардлага болох 100 мянган ам.долларын шаардлагыг хүчингүй болгосон.</li> <li>-“Хөрөнгө оруулалтын дэмжлэг” гэсэн нэр томъёог олон улсын жишигт нийцүүлж, “хөрөнгө оруулалтын урамшуулал” (investment incentive) гэж өөрчилсөн.</li> <li>-Хөрөнгө оруулалтыг дэмжих (investment promote) гэсэн томъёоллыг олон улсад хэрэглэгддэг агуулгын дагуу тодорхойлж хуулийн төсөлд тусгасан. Энэ хүрээнд хөрөнгө оруулалтыг дэмжих бодлого нь хөрөнгө оруулалтыг татахын тулд хөрөнгө оруулагчид үйлчлэх, мэдээлэх зэрэг чиг үүргийг тодорхойлсон байна.</li> <li>-шууд бус хөрөнгө оруулалт буюу портфолио хөрөнгө оруулалтыг тодорхойлолтыг тусгасан.</li> <li>-хөрөнгө оруулалтын гомдол гэсэн нэр томъёог томъёолсон.</li> </ul>

			<p>-гадаадын төрийн өмчит хуулийн этгээдэд зөвшөөрөл олгох зохицуулалтыг хассан тул нэр томъёог хассан.</p> <p>5. Хөрөнгө оруулалт гэсэн агуулгыг өмнөх хуулийн дагуу тодорхойлсныг хэвээр үлдээсэн. Харин хөрөнгө оруулалт хийх хэлбэрийн хүрээг илүү өргөжүүлсэн. Энэ хүрээнд техник хэрэгсэл, үйл ажиллагаагаар хөрөнгө оруулах боломжийг тодорхойлсон.</p> <p>Мөн хөрөнгө оруулалтад хамаарахгүй хэлбэрүүдийг нарийвчлан тусгасан.</p>
2	Хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг	<p>6 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын нийтлэг баталгаа</p> <p>7 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн эрх</p> <p>8 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн үүрэг</p>	<p>6.Хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа шийдвэрийн талаар урьдчилан мэдээлэх, хэлэлцүүлэх, саналаа илэрхийлэх боломж олгох, албан ёсоор хэвлэн нийтэлж нээлттэй байлгах баталгааг тусгасан.</p> <p>Хөрөнгийг зөвхөн гагцхүү нийтлэг ашиг сонирхлын үүднээс үл ялгаварлах зарчмаар, зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу, нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно. Хөрөнгийг дайчлан авах бол бүрэн хэмжээгээр тооцож, зохих ёсоор шуурхай олгох бөгөөд энэхүү нөхөх олговорт ирээдүйд олон ашиг, орлогыг тооцохгүй гэсэн олон улсын зарчмыг тусгасан.</p> <p>Үнэлгээний шалгуур тогтоох журмыг мөн хуулийн төсөлд тусгасан бөгөөд үүнд: хөрөнгийн өнөөгийн үнэ цэн, хөрөнгийн татвар төлсөн үнэлгээг оролцуулсан хөрөнгийн үнэлгээ болон зохистой гэж үзвэл бодит зах зээлийн үнэлгээг тооцож, үнийн хамт төлөхөөр тусгасан.</p> <p>7.Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалт хийх эрх нээлттэй гэж тодорхойлсон. Хөрөнгө оруулалт хийх хязгаарласан салбарыг зөвхөн хуулиар тогтоох бөгөөд энэ хүү мэдээлийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулагч, олон нийтэд шийдвэр гаргах тухай бүр байнга мэдээлж байхыг төсөлд тусгасан.</p> <p>8.Хөрөнгө оруулагчийн үүргийг тодорхойлохдоо Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийг заасан бөгөөд хөрөнгө оруулалтыг бодитой гүйцэтгэх ёстой ба бодитой хийсэн хөрөнгө оруулалт гэснийг хуулийн төсөлд тодорхойлсон.</p>
3	Хөрөнгө оруулалтын талаарх төрийн байгууллагын чиг үүрэг	<p>9 дүгээр зүйл.Засгийн газрын чиг үүрэг</p> <p>10 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг</p> <p>11 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг</p> <p>12 дугаар зүйл.Хөрөнгө</p>	<p>9.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэгтэй. Хөрөнгө оруулалтын гомдлыг хүлээн авч, эцэслэн шийдвэрлэх, төрийн байгууллагуудад чиглэл өгөх чиг үүргийг шинээр бий болгосон.</p> <p>10.Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулагчид үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн</p>

		<p>оруулалтын талаар төрийн бусад байгууллагын чиг үүрэг  13 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын талаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг  14 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтыг дэмжих талаар Дипломат төлөөлөгчийн газрын бүрэн эрх</p>	<p>төрийн захиргааны төв байгууллага буюу Эдийн засаг, хөгжлийн яам дангаараа хэрэгжүүлэхээр заасан.  Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тогтворжуулах гэрчилгээ олгох чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд эрх бүхий бусад төрийн байгууллагатай хамтран хэрэгжилтэд хяналт тавих зохицуулалтыг тусгасан.  11.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, өргөжүүлэх зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, хөрөнгө оруулагчид мэдээлэл, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашгийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх, хөрөнгө оруулалтын орчны чиглэлээр нэгдсэн статистик мэдээллийг гаргах, мэдээллийн санг хөтлөх чиг үүрэгтэй ажиллахаар тусгасан.  12.Төрийн бусад байгууллага нь хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт хяналт, шалгалтыг жилд 2-оос илүүгүй хийх, хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг хууль бус үндэслэлээр зогсоох, түдгэлзүүлэх, саад учруулахыг хориглоно. Энэ тохиолдолд хууль бусаад хөрөнгө дайчлан авсанд тооцох талаар тусгасан. Мөн хүчин төгөлдөр шүүх, арбитрын шийдвэрээр төрөөс хохирлыг нөхөн төлөх шийдвэр гарсан бол учруулсан хохирлыг буруутай этгээдээр гаргуулах үндэслэл болно.  13.Орон нутгийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллага нь мөн төрийн бусад байгууллагын чиг үүргийг гүйцэтгэж, хуульд заасан хариуцлагыг хүлээнэ. Ингэснээр хөрөнгө оруулагч нарын үйл ажиллагаанд хууль бусаар саад учруулж буй төрийн хүнд суртал, нэмэлт шаардлагыг бууруулах ач холбогдолтой.  14.Дипломат төлөөлөгчийн газар нь хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл, хөтөлбөрийг сурталчлах, холбох, дэмжлэг үзүүлэх зэрэг чиглэлээр хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллахаар тусгасан. Энэ харилцааг зохицуулах журмыг гадаад харилцааны болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлахаар тусгасан.</p>
4	Хөрөнгө оруулалтын урамшуулал	<p>15 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын урамшуулал  16 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын татварын бус урамшуулал  17 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын татварын хувь хэмжээг тогтворжуулах урамшуулал</p>	<p>15.Хөрөнгө оруулалтын хуулиар татварын бус урамшуулал болон татварын хувь хэмжээ тогтворжуулах урамшууллыг үзүүлэх боломжтой.  16.Татварын бус урамшуулал нь хөрөнгө оруулагч үйл ажиллагаа явуулахад шаардлагатай дэмжлэг болно. Үүнд, газрын асуудал, ажиллах хүчний зөвшөөрөл, улсын бүртгэлийн асуудал, оршин суух зөвшөөрөл</p>

		<p>18 дугаар зүйл. Тогтворжуулах гэрчилгээ олгох тавигдах шаардлага</p> <p>19 дүгээр зүйл. Тогтворжуулах гэрчилгээ авах тухай хүсэлт гаргах</p> <p>20 дугаар зүйл. Тогтворжуулах гэрчилгээ олгох</p> <p>21 дүгээр зүйл. Тогтворжуулах гэрчилгээг хүчингүй болгох</p> <p>22 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын гэрээ</p> <p>23 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах</p> <p>24 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах</p> <p>25 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээний хэрэгжилтэд хяналт тавих</p>	<p>зэрэг үйл ажиллагаа явуулахад үзүүлэх урамшууллыг хамруулсан. Одоо байгаа хуулийн хүрээнд 60 хүртэл жилээр газар ашиглуулах талаар заасан бол үүнийг Газрын тухай хуульд заасан газар эзэмших эрхтэй холбоотойгоор 15-60 жил гэж хамгийн бага хугацааг тодорхой болгосон. Мөн газрын асуудлыг заавал Засгийн газар бус Газрын тухай хуульд заасны дагуу холбогдох орон нутаг өөрөө шийдэх эрхийг олгосон.</p> <p>17. Татвар тогтворжуулах гэрчилгээ олгох, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах замаар татварын хувь хэмжээ тогтворжуулах урамшууллыг олгохоор заасан. Энэ хүрээнд 4 төрлийн татварыг тогтворжуулах одоогийн хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн. Мөн татварыг зөвхөн татварын хуулиар зохицуулах тухай Татварын ерөнхий хуулийн зарчмаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан хэрэгждэггүй хуулийн зохицуулалтыг хүчингүй болгосон. Татварын дэмжлэгийг "урамшуулал" гэж нэрлэн, урамшуулал үзүүлэх хугацаа нь гэрчилгээ олгогдсон өдрөөс эхлэн гэрчилгээний хүчинтэй хугацаанд үзүүлнэ гэж төсөлд тусгасан.</p> <p>18. Тогтворжуулах гэрчилгээ авах журмыг хялбаршуулсан. Тогтворжуулах гэрчилгээг 5-аас доошгүй жилийн хугацаанд төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид олгох бөгөөд нутаг дэвсгэрийг Улаанбаатар хот болон бусад гэж ангилсан. Тогтворжуулах гэрчилгээний хугацааг доод тал нь 10 жил байх бөгөөд хөрөнгө оруулалтын хэмжээг Улаанбаатар хотод 20-50 тэрбум, орон нутагт 10-50 тэрбум төгрөг байхаар төсөлд тусгасан. 15 жил тогтворжуулах төслийн хувьд хөрөнгө оруулалтын хэмжээ 50 тэрбумээс дээш 100 тэрбум, 20 жил тогтворжуулах төслийн хувьд 100 тэмбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр тусгасан.</p> <p>19. Тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлтийг цахим хэлбэрээр гаргах, хүсэлтэд хуулийн этгээдийн баталгаа, танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээ, бизнес төлөвлөгөө, техник, эдийн засгийн үндэслэл, хуульд заасан бол байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг хавсаргахаар тусгасан.</p> <p>20. Тогтворжуулах гэрчилгээг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.</p> <p>21. Тогтворжуулах гэрчилгээг хүчингүй болгох үндэслэлийг тодорхойлсон. Үүнд хуульд заасан өмнөх нөхцөлүүдийг хэвээр үлдээв.</p> <p>22-25. 500 тэрбум төгрөг ба түүнээс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх этгээд нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлтээ илэрхийлсний үндсэн дээр</p>
--	--	---	--

			асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, эрх авсны үндсэн дээр уг гэрээг салбарын сайд, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн сайд хамтран байгуулахаар тусгасан. Уг гэрээний хугацаа нь төслийн хугацаанаас хамаарах бөгөөд энэ нь 20 жилээс багагүй байхаар төсөлд тусгасан.
5	Хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх ажиллагаа	26 дугаар зүйл.Хөрөнгө оруулагч гомдол гаргах, гомдлыг хүлээн авах 27 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл, түүний ажиллах журам 28 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн гомдлыг хянан магадлах 29 дүгээр зүйл.Хөрөнгө оруулагчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэх	Хөрөнгө оруулагч нь төрийн байгууллага, албан хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирол, эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах зорилгоор хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлд гомдол гаргах эрхийг бий болгосон. Уг зөвлөл нь хууль ёсны эрх ашгийг хамгаалах асуудлаар шийдвэр гаргах бус зөвлөн туслах, асуудлыг зуучлан шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Уг зөвлөл нь учирсан нөхцөлийг байдлыг тодруулсны үндсэн дээр шийдвэрлэх саналыг боловсруулан Засгийн газарт танилцуулж, төрийн захиргааны эцсийн шийдвэрийг гаргах боломж бүрдэнэ.
6	Хөрөнгө оруулалтын маргаан	30 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын маргаан	1.Хөрөнгө оруулагч-төр хооронд үүсэх хөрөнгө оруулалтын маргаан. Арбитрын хэлэлцээрийг талууд харилцан тохиролцож бичгээр үйлдсэн байхыг холбогдох Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцид заасан байдаг. Монгол Улс нь ICSID Convention буюу Улс болон гадаад улсын иргэн хооронд хөрөнгө оруулалтын маргааныг шийдвэрлэх тухай конвенцид нэгдэн орсон. Уг Конвенцид арбитрын хэлэлцээрийг бичгээр үйлдсэн байхыг мөн шаарддаг. Хөрөнгө оруулагч, төр хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргаан нь дараах 3 арбитрын хэлэлцээрт үндэслэж арбитрад хандах эрх үүсдэг: (i) хөрөнгө оруулалтын гэрээ (ii) хоёр талт олон улсын гэрээ (iii) хөрөнгө оруулалтын хуульд төр нь хөрөнгө оруулалтын маргааныг олон улсын арбитраар шийдвэрлэх нэг талын зөвшөөрөл (arbitration consent)-ийг өгөх. Энэ тохиолдолд хөрөнгө оруулагч нь арбитрад нэхэмжлэл гаргаснаар нэг талын зөвшөөрлийг хүлээн авсанд тооцох бөгөөд арбитрын хэлэлцээр бичгээр үйлдэгдсэнд тооцох үндэслэл болно. Хуулийн төсөлд (iii)-т дурдсан төрийн зөвшөөрлийг олгож байгаа нь онцлог зохицуулалт болсон. Энэ зарчим олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, бөгөөд ийм зохицуулалтыг тусгасан олон улс орон үндэсний хууль тогтоомждоо тусгасан байдаг. 2.Шүүхийн онцгой харьяалалд хамааруулсан маргаан. Татвар, газар зэрэг шүүхийн онцгой харьяалалд хамааруулсан маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлэхийг төслийн 32.3-т заасан.

			<p>3.Иргэн, хуулийн этгээд хоорондын арилжааны маргаан.</p> <p>Арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцоо зарчмын дагуу байгуулагддаг буюу маргаанаа шийдвэрлүүлэх арбитраа талууд хэлэцээрийн хүрээнд тохиролцдог. Арбитрын хэлэлцээртэй бол талууд арилжааны маргаанаа арбитрын дагуу шийдвэрлүүлэх, ийм тохиролцоогүй бол Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлэх ерөнхий заалт оруулсан.</p>
7	Бусад зүйл	<p>31 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хариуцлага хүлээлгэх</p> <p>32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт</p> <p>33 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох</p>	<p>Хууль хүчин төгөлдөр болсноор өмнөх хуулийн дагуу гэрчилгээ авсан, гэрээ байгуулсан байгуулсан этгээдийн эрх ашгийг хэрхэн шийдвэрлэх талаарх зохицуулалтыг тусгасан. Хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэхт болон хууль хүчин төгөлдөр болох заалтыг тусгасан.</p>

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын баталгааг тогтоох, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж

2.1.Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

##### 3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хөрөнгө оруулагчаас хийж байгаа хөрөнгө оруулалтыг дэмжих, урамшуулах, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хөрөнгө оруулалтын баталгааг тогтоох, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцаанд хамаарна.

3.2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу төрийн байгууллага, албан газарт улсын болон орон нутгийн төсвөөс хийх хөрөнгө оруулалтад энэ хууль хамаарахгүй.

3.3.Олон улсын болон төрийн бус байгууллага, хувийн өмчит аж ахуйн нэгж, иргэнээс арилжааны нөхцөлгүйгээр олгох хандив, буцалтгүй тусламжид энэ хууль хамаарахгүй.

3.4.Хувьцаа, бонд, үнэт цаас болон бусад санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийг тодорхой хугацаанд өсгөж үр өгөөжийг нь хүртэх зорилгоор санхүүгийн деривативуудад байршуулсан шууд бус хөрөнгө оруулалтад энэ хууль хамаарахгүй.

##### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“хөрөнгө оруулалт” гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан, санхүүгийн тайланд туссан биет болон биет бус хөрөнгийг;

4.1.2.“хөрөнгө оруулагч” гэж энэ хуульд заасан хэлбэрээр Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа гадаад, дотоодын хөрөнгө оруулагчийг;

4.1.3."дотоодын хөрөнгө оруулагч" гэж хөрөнгө оруулалт хийж байгаа хувь хүн /Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн/, Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг;

4.1.4."Монгол Улсад байнга оршин суугч гадаадын иргэн" гэж Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 5.3.1 дэх заалтад заасан нөхцөл хангасан гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг;

4.1.5."гадаадын хөрөнгө оруулагч" гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж байгаа хувь хүн /гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн/, гадаад улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийг;

4.1.6."гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээд" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцаа, хөрөнгө, саналын эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа компани, нөхөрлөлийг;

4.1.7."шууд бус хөрөнгө оруулалт" гэж хувьцаа, бонд болон бусад санхүүгийн хөрөнгийн өгөөжийг хүртэх зорилгоор тэдгээрийг нээлттэй зах зээлээс худалдан авч тодорхой хугацаанд эзэмшихийг (үнэт цаасыг нь эзэмшиж буй хуулийн этгээдийн удирдлагад оролцдоггүй, эрх, үүрэггүй);

4.1.8."хөрөнгө оруулалтын урамшуулал" гэж хөрөнгө оруулагчид төрөөс үзүүлэх татварын хувь хэмжээг тогтворжуулах болон татварын бус урамшууллыг;

4.1.9."татварын хувь, хэмжээг тогтворжуулах" гэж энэ хуульд заасан татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээ эсхүл хөрөнгө оруулалтын гэрээний хүчинтэй хугацаанд тогтвортой мөрдөгдөхийг;

4.1.10."татварын хувь, хэмжээг тогтворжуулах гэрчилгээ" гэж энэ хуулийн 18.1-д заасан шалгуурыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээдэд энэ хуульд заасан татварын хувь, хэмжээг тогтворжуулах зорилгоор эрх бүхий байгууллагаас олгох гэрчилгээг /цаашид "тогтворжуулах гэрчилгээ" гэх/;

4.1.11."тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч" гэж энэ хуульд заасны дагуу тогтворжуулах гэрчилгээ авсан хуулийн этгээдийг;

4.1.12."хөрөнгө оруулалтыг дэмжих" гэж хөрөнгө оруулалтыг шинээр татах, хадгалах, нэмэгдүүлэх зорилгоор маркетинг, мэдээллийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг;

4.1.13."хөрөнгө оруулагчийн гомдол" гэж төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчаас эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар энэ хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу гаргасан хүсэлтийг;

## **5 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа**

5.1.Хөрөнгө оруулагч нь дараах хэлбэрээр хөрөнгө оруулалт хийж болно:

5.1.1.хөрөнгө оруулагч дангаараа, эсхүл хамтран аж ахуйн нэгж байгуулах;

5.1.2.энэ хуулийн 4.1.7-д зааснаас бусад хэлбэрээр хувьцаа, өрийн бичиг, бусад төрлийн үнэт цаасыг худалдан авах;

5.1.3.үйлдвэр, машин механизм, технологи дамжуулах, барилга байгууламж зэрэг үндсэн хөрөнгөд биет байдлаар хөрөнгө оруулалт хийх;

5.1.4.компанийг нэгтгэх, нийлүүлэх замаар хөрөнгө оруулалт хийх;

5.1.5.төр, хувийн хэвшлийн түншлэл, бүтээгдэхүүн хуваах гэрээ, маркетинг, менежментийн болон бусад гэрээ байгуулах;

5.1.6.санхүүгийн түрээс /лизинг/-ийн болон франчайзийн хэлбэрийн хөрөнгө оруулалт хийх;

5.1.7.оюуны өмчийн эрхийг холбогдох хуульд заасны дагуу эдийн засгийн эргэлтэд оруулахад хөрөнгө оруулалт хийх;

5.1.8.хөрөнгө оруулагчаас өөрийн хөрөнгө оруулсан хуулийн этгээдийн хувьцаанд хөрвөх зээл олгох;

5.1.9.хөрөнгө оруулалтын тодорхойлолтод хамаарах хуулиар хориглоогүй бусад хөрөнгө оруулалтын хэлбэр.

5.2.Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосноос бусад салбар, нутаг дэвсгэрт хөрөнгө оруулалт хийж болно.

5.3.Төрөөс үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засгийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хууль тогтоомжоор гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хязгаарлаж болно.

5.4.Энэ хуулийн 5.3-т заасны дагуу Монгол Улсын хууль тогтоомжоор гадаадын шууд хөрөнгө оруулалт хийхийг хориглосон, хязгаарласан хөрөнгө оруулалтын салбар, үйлдвэрлэл, үйлчилгээний жагсаалт болон нутаг дэвсгэрийн мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэр гарснаас хойш 10 хоногт багтаан нийтэд тогтмол мэдээлнэ.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАТАЛГАА, ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

### **6 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын нийтлэг баталгаа**

6.1.Төрөөс хөрөнгө оруулагчийн дараах нийтлэг баталгааг хангана:

6.1.1.хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;

6.1.2.Хууль тогтоомжийн тухай хуулийн 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 27, 62.1-д зааснаар хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа шийдвэрийн талаар урьдчилан мэдээлэх, хэлэлцүүлэх, саналаа илэрхийлэх боломж олгох, албан ёсоор хэвлэн нийтэлж нээлттэй болгох;

6.1.3.төрийн байгууллага, албан хаагчийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн бол түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, учирсан хохирлыг хуульд заасны дагуу барагдуулах;

6.1.4.төрийн байгууллага, албан хаагч нь хөрөнгө оруулагчийн оюуны өмчийн эрх, оюуны өмчийн эрх эзэмшигчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд заасны дагуу хамгаалах;

6.1.5.хөрөнгө оруулагчийн хөрөнгө, орлогыг хууль бусаар дайчлан авахыг хориглоно.

6.2.Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс үл ялгаварлах зарчмаар, зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан авч болно.

6.3.Энэ хуулийн 6.2-т заасны дагуу хөрөнгийг дайчлан авах бол нөхөх олговрыг бүрэн хэмжээгээр бодитоор тооцож, зохих ёсоор шуурхай олгох бөгөөд энэхүү нөхөх олговорт ирээдүйд олох ашиг, орлогыг тооцохгүй.

6.4.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 6.2-т заасны дагуу дайчлан авсан хөрөнгийн нөхөх олговрыг тухайн хөрөнгийг дайчлан авсан үеийн буюу энэ тухай хөрөнгө оруулагчид, эсхүл нийтэд мэдэгдэх үеийн зах зээлийн үнэлгээг холбогдох хууль тогтоомжид тусгасан аргачлалын дагуу тооцож, үнийн хамт төлнө.

6.5.Үнэлгээний шалгуурт хөрөнгийн өнөөгийн үнэ цэнэ, хөрөнгийн татвар төлсөн үнэлгээг оролцуулсан хөрөнгийн үнэлгээ болон зохистой гэж үзвэл бодит зах зээлийн үнэлгээг тооцох бусад шалгуурыг оролцуулна.

6.6.Нөхөх олговор нь хуульд өөрөөр заагаагүй бол бүрэн хөрвөх чадвартай, чөлөөтэй шилжүүлж болохуйц байна.

6.7.Хөрөнгө оруулагч дараах өөрт ногдох хөрөнгө, орлогыг гадаад улсад саадгүй гаргах баталгааг эдэлнэ. Энэ хэсэгт заасан баталгааг эдлэхдээ Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүргээ бүрэн биелүүлж, хүчин төгөлдөр шүүхийн болон арбитрын шийдвэрийн дагуу тогтоогдсон бусдад төлөх мөнгөн төлбөрийн үүрэг, төлбөр, хураамж, торгууль зэргийг бүрэн барагдуулсан байна:

6.7.1.үйл ажиллагаанаас олсон ашиг, ногдол ашиг;

6.7.2.энэ хуулийн 5.1-д заасан үйл ажиллагаанаас бий болсон аливаа орлого, төлбөр;

6.7.3.гадаад улсаас олгосон зээлийн үндсэн төлбөр болон хүү;

6.7.4.аж ахуйн нэгжийг татан буулгасны дараа өөрт ногдох хөрөнгө;

6.7.5.хуулийн хүрээнд олсон буюу өмчилж байгаа бусад хөрөнгө;

6.7.6.энэ хуулийн 6.3-т заасан нөхөх олговор.

6.8.Хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 6.7-д заасан хөрөнгө, орлогыг мөнгөн хөрөнгө хэлбэрээр гадаад улсад гаргахдаа хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн сонгосон валютад хөрвүүлэн шилжүүлэх эрхтэй.

## **7 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн эрх**

7.1.Хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан баталгаанаас гадна дараах нийтлэг эрхтэй:

7.1.1.хөрөнгө оруулалт хийх хэлбэр, хэмжээ, хөрөнгө оруулалт хийх газар, бүс нутаг зэргийг хараат бусаар сонгох, холбогдох шийдвэрийг бие даан гаргах;

7.1.2.хөрөнгө оруулах төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гадаад улсаас бараа, ажил, үйлчилгээ импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг экспортлох;

7.1.3.Монгол Улсад бүртгэлтэй банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан гадаадын мөнгөн тэмдэгт худалдан авах, худалдах зэргээр өөрийн гадаад валютын хэрэгцээг хангах;

7.1.4.хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг удирдах буюу удирдахад оролцох, бусад этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх, үүргээ шилжүүлэх;

7.1.5.санхүүжилт, зээл, тусламж, газар, байгалийн баялаг ашиглах хүсэлт гаргах, хүсэлтээ шийдвэрлүүлэх;

7.1.6.төрийн үйлчилгээг эрх тэгш хүлээн авах;

7.1.7.хууль тогтоомжид заасан бусад эрх.

## **8 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн үүрэг**

8.1.Хөрөнгө оруулагч нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах үндсэн үүргээс гадна дараах нийтлэг үүрэгтэй:

8.1.1.үйлдвэрлэж байгаа бараа, үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад нийцсэн байх;

8.1.2.нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын стандартад нийцүүлэн хөтлөх;

8.1.3.татварын байгууллага болон бусад төрийн байгууллагаас хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан мэдээллийг заасан хугацаанд гаргаж өгөх;

8.1.4.хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа нь хэрэглэгчийн эрх ашгийг дээдэлж, зах зээлд шударгаар өрсөлдөх, байгаль орчинд ээлтэй байж, хүний хөгжлийг дэмжих;

8.1.5.хууль тогтоомжид заасны дагуу татвар, ажилтны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг төлөх, тайлагнах;

8.1.6.удирдлагын сайн засаглалын зарчмыг нэвтрүүлэх, удирдлага, менежментийг сайжруулах бодлого хэрэгжүүлэх, хүний эрхийг хангаж ажиллах төлөвлөгөө боловсруулах, тогтмол дүн шинжилгээ хийх, ажилтны мэдлэг, туршлага, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх;

8.1.7.Монгол Улсын үндэсний түүх соёл, өв уламжлал, ёс заншлыг хүндэтгэх;

8.1.8.хөрөнгө оруулалтаа бодитоор хийсэн байх;

8.1.9.эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, хөдөлмөрийн стандартыг хангаж ажиллах;

8.1.10.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

8.2.Энэ хуулийн 8.1.8-д заасан хөрөнгө оруулалтыг бодитоор хийсэн эсэхийг доор дурдсан шалгуурыг харгалзан тогтооно:

8.2.1.тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны шинж чанар, зорилгод нийцсэн байх;

8.2.2.бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа хугацаа, хууль тогтоомжийн дагуу төлсөн татварын хэмжээ;

8.2.3.хөрөнгө оруулагчийн үйлчлүүлэгчийн тоо эсхүл бий болгосон ажлын байрны тоо;

8.2.4.эдийн засагт эерэг нөлөө үзүүлсэн байдал.

8.3.Хөрөнгө оруулагч нь аливаа дэмжлэг, урамшуулал, зөвшөөрөл, эрх авах, гэрээ байгуулах зорилгоор эрх бүхий албан тушаалтанд мөнгөн төлбөр, бэлэг, үйлчилгээ, ашигтай нөхцөл санал болгох, амлах, олгохыг хориглоно.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРЭГ**

#### **9 дүгээр зүйл.Засгийн газрын чиг үүрэг**

9.1.Засгийн газар хөрөнгө оруулалтын чиглэлээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1.хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хэрэгжилтийг хангах;

9.1.2.энэ хуульд заасан хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрх олгох;

9.1.3.хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудлаар шийдвэр гаргах;

9.1.4.хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын баталгааг хангах, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр холбогдох төрийн байгууллагад чиглэл өгөх.

9.2.Засгийн газар энэ хуулийн 24.4, 25.6, 30.5-д заасан журмыг тус тус баталж, мөрдүүлнэ.

#### **10 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

10.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн биелэлтийг хангах, хяналт тавих;

10.1.2.хөрөнгө оруулалтын бодлого, хөрөнгө оруулалтад үзүүлэх дэмжлэг, урамшуулал, арга хэмжээний талаар санал боловсруулан Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

10.1.3.хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах асуудлаар Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

10.1.4.тогтворжуулах гэрчилгээ олгох, эрх бүхий бусад төрийн байгууллагатай хамтран хэрэгжилтэд хяналт тавих;

10.1.5.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай тайлан, мэдээллийг холбогдох төрийн байгууллага, хөрөнгө оруулагчаас гаргуулан авах;

10.1.6.энэ хуулийн 9.2-т заасан журмын төслийг боловсруулах;

10.1.7.хуульд заасан бусад чиг үүрэг.

10.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ хуулийн 11.1.7-д заасантай холбоотой журмыг баталж мөрдүүлнэ.

## **11 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

11.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.1.хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, өргөжүүлэх зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

11.1.2.хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, мэдээллээр хангах;

11.1.3.хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, өргөтгөх, хадгалахад мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар дэмжлэг үзүүлэх;

11.1.4.хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;

11.1.5.хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх;

11.1.6.хөрөнгө оруулалт татахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, сонирхогч этгээдийг мэдээллээр хангах;

11.1.7.хөрөнгө оруулалтын орчны чиглэлээр төв банк, төсөв, санхүү, хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, нийгмийн даатгал, бүртгэл, гадаадын иргэн, харьяат, газар, чөлөөт бүс болон шүүхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас хөрөнгө оруулалттай холбоотой статистик мэдээллийг улирал, хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгдсэн статистик мэдээллийг гаргах;

11.1.8.хөрөнгө оруулалтын асуудлаарх мэдээллийн санг хөтлөх;

11.1.9.хуульд заасан бусад.

11.2.Энэ хуулийн 11.1.8-д заасан мэдээллийн сан нь нийтэд ил тод байх ба дараах мэдээллийг агуулсан байна:

11.2.1.хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, хөрөнгө оруулалтыг хамгаалах талаарх Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ конвенц;

11.2.2.хөрөнгө оруулалт, санхүүжилтийн эх үүсвэр шаардлагатай төслийн мэдээлэл;

11.2.3.татварын хувь хэмжээг тогтворжуулах урамшуулал авсан хөрөнгө оруулагч, түүний оруулсан хөрөнгө оруулалтын талаарх мэдээлэл;

11.2.4.Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөлд ирсэн, шийдвэрлэсэн хөрөнгө оруулагчийн гомдлын статистик мэдээлэл, (ямар байгууллагад, ямар асуудлаар ирсэн талаарх мэдээллийг гомдол гаргагчийн мэдээллийг таних боломжгүйгээр харуулсан байна);

11.2.5.хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэсэн талаарх Засгийн газраас гаргасан шийдвэр;

11.2.6.энэ хуулийн 11.2.5-д заасан гомдлын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;

11.2.7.нууцад хамааруулснаас бусад тохиолдолд хөрөнгө оруулалттай холбоотой төрөөс хариуцагчаар татагдсан хэрэг маргааны талаарх мэдээлэл;

11.2.8.хөрөнгө оруулалтын талаарх статистик мэдээлэл;

11.2.9.гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн талаарх статистик мэдээлэл;

11.2.10.хуулиар хориглоогүй бусад мэдээлэл.

11.3.Хөрөнгө оруулагчийн талаар мэдээлэл харилцан солилцох, хамтран ажиллах, хууль тогтоомжийг сурталчлан таниулах журмыг хөрөнгө оруулалтын болон холбогдох асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хамтран батална.

**12 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын талаар төрийн бусад байгууллагын чиг үүрэг**

12.1.Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Засгийн газар болон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлтийг хангаж, шаардлагатай мэдээлэл, хэрэгжилтийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад тухай бүр гаргаж өгнө.

12.2.Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд хийх төрийн хяналт шалгалтыг давхардалгүй төлөвлөж, хэрэгжүүлнэ.

12.3.Хуульд зааснаас бусад тохиолдолд хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд хийх төлөвлөгөөт хяналт шалгалтын тоо жилд хоёроос ихгүй байна.

12.4.Хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалттай холбоотой гаргасан санал, хүсэлтийг шийдвэрлэхэд өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар тайлбар, мэдээлэл, санал, зөвлөмж гаргана.

12.5.Бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлэсэн, эсхүл эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлсэн хөрөнгө оруулагчаас гаргасан санал, гомдлын талаарх мэдээллийг энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан журмын дагуу хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын мэдээллийн санд бүртгүүлнэ.

12.6.Хууль бус үндэслэлээр хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг аливаа хэлбэрээр зогсоох, түдгэлзүүлэх, саад учруулахыг хориглоно.

12.7.Хөрөнгө оруулагчийг хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай зөвшөөрөл, эрх авах, гэрээ байгуулах зэрэгт үндэслэлгүйгээр татгалзах, эс үйлдэхүй гаргахыг хориглоно.

12.8.Энэ хуулийн 12.6, 12.7-д заасныг зөрчиж үндэслэлгүйгээр хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашгийг хохироосон нь эрх бүхий этгээдийн шийдвэрээр тогтоогдсон бол хууль бусаар хөрөнгө дайчлан авсанд тооцох үндэслэл болно.

12.9.Энэ хуулийн 12.8-д заасан үндэслэлээр хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж, хохироосон бол хөрөнгө оруулагч нь уг хохирлыг холбогдох шийдвэр гаргах төрийн байгууллагаас нэхэмжлэх эрхтэй.

12.10.Энэ хуулийн 12.6, 12.7-д заасан үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоотойгоор хөрөнгө оруулагч нь гомдол, нэхэмжлэл гаргаж, хүчин төгөлдөр шүүх, арбитрын шийдвэрээр төрөөс хохирлыг нөхөн төлөх шийдвэр гарсан бол буруутай албан тушаалтныг ажлаас чөлөөлөх, хөрөнгө оруулагчид учруулсан хохирлыг (төрөөс гаргасан шүүх, арбитрын төлбөр зэргийг хамруулна) буруутай этгээдээр төлүүлэх үндэслэл болно.

12.11. Сонсох ажиллагаа хийлгүйгээр хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хохиролтой шийдвэр гаргасан бол энэ нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу уг шийдвэр хүчингүй болох үндэслэл болно.

12.12. Энэ хуулийн 6.1.2-т заасны дагуу хууль тогтоомж, эрх зүйн актын төсөл боловсруулах тохиолдолд эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээд болон хөрөнгө оруулагчаас санал авах, эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт боловсруулна.

### **13 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын талаар нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүрэг**

13.1. Хөрөнгө оруулалтын хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан Засгийн газар, эрх бүхий этгээдийн шийдвэрийн биелэлтийг харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, хэрэгжилтийг хангуулна.

13.2. Харьяалах нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчдад хуульд заасан дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тайлан, мэдээллийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

13.3. Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасныг нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтан мөрдөж ажиллана.

### **14 дүгээр зүйл. Хөрөнгө оруулалтыг дэмжих талаар Дипломат төлөөлөгчийн газрын бүрэн эрх**

14.1. Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар нь Монгол Улсын хөрөнгө оруулалтын хууль, эрх зүйн орчин, дотоод зах зээлийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт эрэлхийлсэн төсөл, хөтөлбөрийг сурталчлах, холбох, дэмжлэг үзүүлэх зэрэг хуульд заасан бусад чиглэлээр ажиллана.

14.2. Энэ хуулийн 14.1-д заасныг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллана.

14.3. Дипломат төлөөлөгчийн газар энэ хуулийн 14.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэх журмыг хөрөнгө оруулалтын болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УРАМШУУЛАЛ**

### **15 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын урамшуулал**

15.1. Хөрөнгө оруулагчид төрөөс татварын хувь хэмжээг тогтворжуулах урамшуулал болон татварын бус урамшууллыг үзүүлж болно.

15.2. Энэ хуульд заасан татварын хувь хэмжээг тогтворжуулахаас бусад төрлийн татварын урамшууллыг татварын хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

15.3. Тамхи, согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, галт зэвсэг, сум үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах үйл ажиллагаанд хөрөнгө оруулалтын урамшуулал үзүүлэхгүй.

### **16 дугаар зүйл. Хөрөнгө оруулалтын татварын бус урамшуулал**

16.1.Хөрөнгө оруулагчид дараах хэлбэрээр хөрөнгө оруулалтын татварын бус урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу үзүүлж болно:

16.1.1.газрыг 15-60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах;

16.1.2.чөлөөт бүс, үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулах хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бүртгэлийн болон шалган нэвтрүүлэх хөнгөвчилсэн горимоор үйлчлэх;

16.1.3.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаад ажилтныг ажлын байрны төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх;

16.1.4.экспортод чиглэсэн инновацын бүтээгдэхүүн үйлдвэрлэл, инновацын төслийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

16.1.5.Монгол Улсад хөрөнгө оруулалт хийсэн гадаадын хөрөнгө оруулагч, түүний гэр бүлд Монгол Улсад зорчих олон удаагийн орж гарах виз болон байнга оршин суух зөвшөөрлийг олгох;

16.1.6.хуульд заасан бусад урамшуулал.

## **17 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын татварын хувь хэмжээг тогтворжуулах урамшуулал**

17.1.Хөрөнгө оруулагчид тогтворжуулах гэрчилгээ олгох замаар доор дурдсан татварын хувь хэмжээг тогтворжуулах урамшууллыг олгоно:

17.1.1.аж ахуйн нэгжийн орлогын албан татвар;

17.1.2.гаалийн албан татвар;

17.1.3.нэмэгдсэн өртгийн албан татвар;

17.1.4.ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.

17.2.Тогтворжуулах гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд уг гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хувь, хэмжээг тогтворжуулна.

17.3.Тогтворжуулах гэрчилгээний хүчинтэй байх хугацаанд татварын хууль тогтоомжид энэ хуулийн 17.1-д заасан татварын хувь, хэмжээг бууруулах өөрчлөлт орсон тохиолдолд тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд уг өөрчлөлтөд хамаарах ба харин нэмэгдүүлэх өөрчлөлт орсон тохиолдолд уг өөрчлөлтөд хамаарахгүй.

17.4.Ашигт малтмалын үүсмэл ордоос олборлосон ашигт малтмалын бүтээгдэхүүнд энэ хуулийн 17.1.4-т заасан тогтворжуулах урамшуулал хамаарахгүй.

## **18 дугаар зүйл.Тогтворжуулах гэрчилгээ олгох нөхцөл, тавигдах шалгуур**

18.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт таваас доошгүй жилийн хугацаанд төсөл хэрэгжүүлэх хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын хэмжээ, нутаг дэвсгэрээс хамаарч доор дурдсан хугацаагаар тогтворжуулах гэрчилгээг олгоно:

№	Хөрөнгө оруулалтын хэмжээ /төгрөг/		Тогтворжуулах гэрчилгээний хугацаа /жил/
	Улаанбаатар хот	Бусад	
1	20,000,000,000-50,000,000,000	10,000,000,000-50,000,000,000	10
2	50,000,000,001-100,000,000,000		15
3	100,000,000,001-ээс дээш		20

18.2.Тогтворжуулах гэрчилгээний загварыг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах бөгөөд уг гэрчилгээнд дараах мэдээллийг тусгана:

18.2.1.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар;

18.2.2.хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төслийн нэр, хөрөнгө оруулалтын хэмжээ, хэрэгжих хугацаа;

18.2.3.тогтворжуулах гэрчилгээ олгосон он, сар, өдөр, хүчинтэй байх хугацаа;

18.2.4.энэ хуулийн 17.1-д заасан татварын хувь, хэмжээ.

18.3.Тогтворжуулах гэрчилгээг бусдад худалдах, барьцаалах, бэлэглэх, шилжүүлэхийг хориглоно.

18.4.Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд нь нэгтгэх, нийлүүлэх, өөрчлөх хэлбэрээр өөрчлөн зохион байгуулагдахад тогтворжуулах гэрчилгээ нь шинээр бий болсон буюу эрх залгамжлан авсан хуулийн этгээдэд дараах шаардлагыг хангасан тохиолдолд үлдсэн хугацаанд багтаан шилжинэ:

18.4.1.хуулийн этгээд нь хөрөнгө оруулалтын төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх;

18.4.2.хөрөнгө оруулалтын төсөл нь энэ хуулийн 18.1-д заасан шалгуурыг хангаж байх.

### **19 дүгээр зүйл.Тогтворжуулах гэрчилгээ авах тухай хүсэлт гаргах**

19.1.Энэ хуулийн 18.1-д заасан шалгуурыг хангасан хөрөнгө оруулагч хуулийн этгээд нь тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлтээ хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар гаргана.

19.2.Тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлтэд доор дурдсан бичиг баримтыг хавсаргана:

19.2.1.энэ хуулийн 18.1-д заасан шалгуурыг хангасан тухай хүсэлт гаргагч хуулийн этгээдийн баталгаа;

19.2.2.хүсэлт гаргагч хуулийн этгээдийн танилцуулга, улсын бүртгэлийн гэрчилгээ, хуульд заасан тохиолдолд эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн баримт бичгийн хуулбар;

19.2.3.хөрөнгө оруулагчийн бизнес төлөвлөгөө, хэрэгжүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл;

19.2.4.хуульд заасан бол байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ.

### **20 дугаар зүйл.Тогтворжуулах гэрчилгээ олгох**

20.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь тогтворжуулах гэрчилгээ авах хүсэлт, холбогдох бичиг баримтыг цахимаар хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хүсэлтийг судалж, тогтворжуулах гэрчилгээ олгох эсэхийг шийдвэрлэнэ. Хэрэв шаардлагатай гэж үзвэл хугацааг 15 хоногоор сунгаж болно.

20.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтворжуулах гэрчилгээнд холбогдох бичилтийг хийж, гэрчилгээг төсөл хэрэгжүүлэгч Монгол Улсад үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдэд олгоно.

20.3.Хөрөнгө оруулалтын төсөл нь энэ хуулийн 18.1-д заасан шалгуурыг хангаагүй нь төслийн техник, эдийн засгийн үндэслэл эсхүл энэ хуулийн 19.2-т заасан бичиг баримтын бүрдэл дутуу тохиолдолд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох үндэслэл бүхий гэрчилгээ олгохоос татгалзсан хариуг энэ хуулийн 20.1-д заасан хугацаанд цахимаар хөрөнгө оруулагчид хүргүүлнэ.

20.4.Энэ хуулийн 18.2-т заасан мэдээлэлд өөрчлөлт орсон тухай бүр тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдийн хүсэлтийг үндэслэн хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтворжуулах гэрчилгээнд өөрчлөлт оруулна.

20.5.Хөрөнгө оруулалтын төслийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын хэлбэрээс хамаарч тогтворжуулах гэрчилгээг дараах этгээдэд олгоно:

20.5.1.хөрөнгө оруулалтын төслийг нэг хуулийн этгээд дангаар хэрэгжүүлэх бол тухайн хуулийн этгээдэд;

20.5.2.хөрөнгө оруулалтын төслийг харилцан хамаарал бүхий хоёр ба түүнээс дээш тооны хуулийн этгээд хэрэгжүүлэх бол тэдгээрийн толгой компанид.

## **21 дүгээр зүйл.Тогтворжуулах гэрчилгээг хүчингүй болгох**

21.1.Тогтворжуулах гэрчилгээг доор дурдсан үндэслэлээр хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр хүчингүй болгоно:

21.1.1.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд хүсэлт гаргасан, эсхүл татан буугдсан;

21.1.2.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд Монгол Улсад оруулсан хөрөнгөө Монгол Улсын нутаг дэвсгэрээс бүрэн татаж, шилжүүлсэн;

21.1.3.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд нь хууль бус бичиг баримт бүрдүүлсэн, эсхүл гэрчилгээ авахтай холбоотой авлига өгч тогтворжуулах гэрчилгээг авсан болох нь тогтоогдсон;

21.1.4.эрх залгамжлагч нь энэ хуулийн 18.4-т заасан шалгуурыг хангаагүй;

21.1.5.энэ хуулийн 18.3-т заасныг зөрчсөн;

21.1.6.тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан.

21.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 21.1-д заасан үндэслэлээр тогтворжуулах гэрчилгээг хүчингүй болгосон шийдвэрээ ажлын таван өдөрт багтаан тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээдэд болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ.

## **22 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ**

22.1.Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн баталгааг хангах, хөрөнгө оруулалтын урамшууллыг олгох зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрх олгоно.

22.2.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хөрөнгө оруулагчийн төлөх энэ хуулийн 17.1-д заасан татварын хувь, хэмжээ нь хөрөнгө оруулалтын гэрээний хугацаанд тогтвортой мөрдөгдөнө.

22.3.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан этгээдэд энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан татварын бус урамшууллыг олгоно.

### **23 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах**

23.1.Хөрөнгө оруулагч нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлтийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

23.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хүсэлтийг хянан үзээд холбогдох хууль тогтоомжид заасан татгалзах үндэслэл тогтоогдоогүй бол хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хэлэлцээнд урих талаар Засгийн газар танилцуулж, зөвшөөрөл авна.

23.3.Ерөнхий сайдын захирамжаар хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хэлэлцээ хийх ажлын хэсгийг байгуулж, хөрөнгө оруулагчтай хэлэлцээ хийх ажиллагааг эхлүүлнэ.

23.4.Хэлэлцээний үр дүнд харилцан тохиролцсон хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

23.5.Засгийн газар тухайн хөрөнгө оруулалтын гэрээний төслийг хэлэлцэн дэмжсэн бол хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон салбарын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тус тус хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурах эрх олгоно.

### **24 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах**

24.1.Энэ хуулийн 23.5-д зааснаар эрх олгогдсоны дагуу холбогдох Засгийн газрын гишүүд нь хөрөнгө оруулагчтай хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна.

24.2.Хөрөнгө оруулалтын гэрээг хөрөнгө оруулалтын зорилго, үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хэмжээ, эх үүсвэр, хөрөнгө оруулах хугацаа, үе шат зэргийг харгалзан тогтворжуулах гэрчилгээний дээд хугацаанаас доошгүй хугацаагаар байгуулна.

24.3.Хөрөнгө оруулалтын гэрээнд хөрөнгө оруулалтын зорилго, хөрөнгө оруулалтын хэмжээ, хөрөнгө оруулах хэлбэр, хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа, төрөөс үзүүлэх хөрөнгө оруулалтын урамшуулал, баталгаа, талуудын хүлээх эрх, үүрэг, хамтын ажиллагаа, зохицуулах хууль, маргаан шийдвэрлэх журмыг заавал тусгасан байна. Хөрөнгө оруулалтын гэрээнд зохицуулалтын болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцөлийг тусгаж болно.

24.4.Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлт гаргах, хэлэлцээ хийх, гэрээ байгуулахад тавигдах шаардлага, хөрөнгө оруулалтын гэрээг байгуулах, хяналт тавихтай холбоотой журам, хөрөнгө оруулалтын гэрээний загварыг Засгийн газар батална.

24.5.Энэ хуулийн 22.1-д заасан хэмжээний хөрөнгө оруулалт хийх тогтворжуулах гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд нь өөрөө хүсэлт гаргавал түүнтэй хөрөнгө оруулалтын гэрээг энэ хуульд заасан журмын дагуу байгуулна.

### **25 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээний хэрэгжилтэд хяналт тавих**

25.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан болон тогтворжуулах гэрчилгээ авсан этгээдийн

хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, хяналт тавьж ажиллана.

25.2.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 25.1-д заасан хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн аудитаар баталгаажсан тайланг жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийн дотор хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар болон цаасан хэлбэрээр хүргүүлнэ.

25.3.Энэ хуулийн 25.1-д заасан хяналтыг холбогдох төрийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж болно.

25.4.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээний хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах талаар зөвлөмж, чиглэл өгч, тайлбар, тодруулга авч болно.

25.5.Хөрөнгө оруулагч энэ хуулийн 25.4-д заасан зөвлөмж, чиглэлийг хэрэгжүүлж, энэ талаарх тайлан, мэдээллийг заасан хугацаанд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

25.6.Энэ хуулийн 25.1-д заасан үйл ажиллагааг зохицуулах журмыг Засгийн газар батална.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА**

### **26 дугаар зүйл.Хөрөнгө оруулагч гомдол гаргах, гомдлыг хүлээн авах**

26.1.Хөрөнгө оруулагч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч нь төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн тухай гомдлыг Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх)-д гаргаж болно.

26.2.Гомдлыг төрийн албан ёсны хэлээр цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргана.

26.3.Хөрөнгө оруулагч нь гомдолд дараах мэдээллийг тусгасан байна:

26.3.1.хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсэн талаарх мэдээлэл, нотлох баримт;

26.3.2.гомдол гаргагчийн, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, оршин суугаа газрын буюу шуудангийн хаяг, холбоо барих утасны дугаар, гарын үсэг;

26.3.3.гомдолд холбогдож байгаа төрийн байгууллага, албан тушаалтны мэдээлэл.

26.4.Зөвлөл нь хөрөнгө оруулагчийн гомдол, түүнд хавсаргасан нотлох баримтыг хүлээн авч бүртгэх ба уг бүртгэл нь хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх хөрөнгө оруулагчийн мэдээллийн сангийн цахим систем /цаашид "Систем" гэх/-д бүртгэгдэнэ.

26.5.Зөвлөл нь гомдлыг хүлээн авч, харьяаллын бус гомдлыг үндэслэл бүхий тайлбарын хамт хөрөнгө оруулагчид ажлын 5 өдрийн дотор буцаана.

26.6.Зөвлөл дараах тохиолдолд гомдлыг хүлээн авахаас татгалзаж, буцаана:

26.6.1.Үндсэн хуулийн цэц, шүүх, мөрдөн шалгах ажиллагааны шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэрэг, маргааны талаарх гомдол;

26.6.2.гадаад улсын арбитр, эсхүл гадаад улсын шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэгдсэн маргаантай холбоотой гомдол;

26.6.4.тагнуул, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, төрийн гадаад бодлогыг шууд хэрэгжүүлэхтэй холбоотой гомдол;

26.6.5.Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын хянан шалгаж байгаа хүний эрхийн зөрчлийн талаарх гомдол;

26.6.6.татварын маргаан таслах зөвлөлөөр хянагдвал зохих татварын акттай холбоотой гомдол;

26.6.7.хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд үл хамаарах гомдол.

## **27 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөл, түүний ажиллах журам**

27.1.Зөвлөл нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба зөвлөлийн гишүүдийг хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний шийдвэрээр томилж, чөлөөлнө.

27.2.Зөвлөлийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь хараат бус байх ба хараат бус гишүүнийг 2 жил тутам, нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж, хамгийн өндөр санал авсан, нөхцөл, шалгуурыг хангасан хүнийг томилно.

27.3.Зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах болон Зөвлөлийн ажиллах журмыг хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална.

27.4.Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хуралдаан байх ба хуралдаанаас гаргах шийдвэр нь зөвлөмж, санал хэлбэртэй байна.

27.5.Зөвлөлийн хуралдаан нь гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчинтэй болох ба шийдвэрийг хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар гаргана.

27.6.Зөвлөл нь ажлын албатай байх ба ажлын албаны чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

27.7.Зөвлөл нь шаардлагатай тохиолдолд хэлэлцэх асуудалтай холбоотой шинжээч томилж, дүгнэлт гаргуулж болно.

## **28 дугаар зүйл.Хөрөнгө оруулагчийн гомдлыг хянан магадлах**

28.1.Зөвлөл энэ хуулийн 26.1-д заасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 хоногт холбогдох төрийн байгууллагад уламжлан, гомдлын талаар дараах утга бүхий тайлбар, мэдээллийг авахаар хүргүүлнэ:

28.1.1.хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа асуудлын талаарх төрийн байгууллага, албан тушаалтнаас авч хэрэгжүүлж байгаа нөхцөл байдлын талаарх мэдээлэл;

28.1.2.цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээлэл, үүнд асуудлыг судлан шийдвэрлэх хугацааны талаарх мэдээллийг хамруулсан байна.

28.2.Төрийн байгууллага, албан тушаалтан нь энэ хуулийн 28.1-д заасан мэдээллийг ажлын 5 хоногт багтаан боловсруулж Зөвлөлд хүргүүлнэ.

28.3.Зөвлөл нь уг хариу мэдээллийг авч, ажлын 5 хоногт хуралдаж, төрийн байгууллагын буруутай үйл ажиллагаа тогтоогдвол холбогдох төрийн байгууллагад зөвлөмж өгч, энэ талаар хөрөнгө оруулагчид мэдэгдэнэ.

28.4.Хөрөнгө оруулагч нь энэ хуулийн 28.3-т заасан зөвлөмж, мэдээллийг хүлээн авснаас хойш асуудлыг шийдвэрлэхээр заасан хугацаанд зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь сэргээгүй, эсхүл уг хугацаа нь хэт урт буюу хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд ноцтой хохирол учруулахаар бол энэ талаар шийдвэр гаргуулахаар Зөвлөлд дахин хандана.

## **29 дүгээр зүйл.Хөрөнгө оруулагчийн гомдлыг эцэслэн шийдвэрлэх**

29.1.Зөвлөл нь энэ хуулийн 28.4-т заасан гомдолтой танилцан, асуудлыг ажлын 5 хоногт багтаан хэлэлцэж, үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн бол энэ талаарх шаардлагатай бүхий л мэдээллийн хамт авах арга хэмжээний санал, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох саналыг боловсруулж, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 5 хоногийн дотор хүргүүлнэ.

29.2.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь хөрөнгө оруулагчийн гомдлыг шийдвэрлэх Хөрөнгө оруулагчийн эрх, ашгийг хамгаалах зөвлөлийн саналд, гомдолд хамаарах асуудал хариуцсан төрийн байгууллага, нутгийн захиргааны байгууллагыг шууд харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтны саналыг авч асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, хууль тогтоомжид нийцүүлэн холбогдох асуудлыг шийдвэрлүүлнэ.

29.3.Гомдолд хамаарах асуудал хариуцсан төрийн байгууллага болон нутгийн захиргааны байгууллагын дээд шатны байгууллага нь энэ хуулийн 29.2-т заасан асуудалд 14 хоногт багтаан заавал санал өгсөн байх ба санал өгөөгүй нь уг асуудалд тусгайлсан саналгүйд тооцох үндэслэл болно.

29.4.Засгийн газраас гаргасан шийдвэрийг холбогдох төрийн байгууллага, албан тушаалтан нь заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд ийнхүү биелүүлээгүй нь тухайн албан тушаалтныг ажлаас чөлөөлөх үндэслэл болно.

29.5.Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 29.2-т заасан шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж, биелэлтэд хяналт тавина.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МАРГААН**

### **30 дугаар зүйл.Хөрөнгө оруулалтын маргаан**

30.1.Монгол Улсын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг талууд хэлэлцээний замаар шийдвэрлэнэ.

30.2.Энэ хуулийн 30.1-д заасан маргааныг 6 сарын дотор хэлэлцээний замаар шийдвэрлэж чадаагүй, талууд өөрөөр харилцан тохиролцоогүй тохиолдолд хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг Хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг зохицуулах олон улсын төвийн арбитрын журмын дагуу шийдвэрлүүлж болно.

30.3.Энэ хуулийн 30.1-д заасан маргаанд холбогдох асуудлыг хуулиар шүүхийн онцгой харьяалалд хамааруулсан бол маргааныг Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

30.4.Гадаадын хөрөнгө оруулагч болон Монгол Улсын хувь хүн, хуулийн этгээд хооронд үүссэн хөрөнгө оруулалтын маргааныг талууд харилцан тохиролцсоны дагуу арбитра хандан шийдвэрлүүлж болно. Хэрэв ийм тохиролцоогүй бол маргааныг Монгол Улсын хуулийн дагуу шийдвэрлэнэ.

30.5.Энэ хуулийн 30.1-д заасан хэлэлцээний замаар маргаан шийдвэрлэх журмыг Засгийн газар батална.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ**

### **31 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

31.1.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

31.2.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

### **32 дугаар зүйл.Шилжилтийн үеийн зохицуулалт**

32.1.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө тогтворжуулах гэрчилгээ авсан хуулийн этгээдийн тогтворжуулах гэрчилгээний хугацаа, нөхцөл нь тухайн гэрчилгээний хугацаанд хүчинтэй байна.

32.2.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын гэрээний хугацаа, нөхцөл тухайн гэрээний хугацаанд хүчинтэй байна.

32.3.Энэ хуулийн 32.1, 32.2-т заасан татварын урамшуулал авсан хөрөнгө оруулагч хэрэгжүүлж буй төсөлтэй холбоотойгоор энэ хуулийн дагуу татварын хувь, хэмжээг тогтворжуулах урамшуулалд хамрагдахгүй.

32.4.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлт гаргасан хуулийн этгээдийн төлөх улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ нь тухайн хүсэлт гаргах үеийн хүчин төгөлдөр хууль тогтоомжийн дагуу төлнө.

32.5.Тогтворжуулах гэрчилгээ авах, хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах хүсэлтийг 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр баталсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэх явцад энэ хууль хүчин төгөлдөр болсон бол ирүүлсэн баримт бичгийн хүрээнд хүсэлтийг шинэ хуульд нийцүүлэн шийдвэрлэнэ.

32.6.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө төрийн хяналт шалгалтын тухайн жилийн нэгдсэн хуваарь батлагдсан бол хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаанд тухайн жилд 2-оос дээш удаа хяналт шалгалт хийж болно.

32.7.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө шүүх, арбитра хандсан хөрөнгө оруулагчийн хөрөнгө оруулалттай холбоотой маргааны хэргийн харьяалалд энэ хууль хамаарахгүй.

### **33 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

33.1.Энэ хуулийг 2023 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## **ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2013 оны 10 дугаар сарын 3-ны өдөр баталсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “саналыг” гэсний дараа “, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах талаар хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “15” гэснийг “30” гэж, 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “аж ахуйн нэгж” гэснийг “хуулийн этгээд” гэж, 16.2.1 дэх заалтын “21.1” гэснийг “26.1” гэж, 16.2.3 дахь заалтын “аж ахуйн нэгжийн” гэснийг “хуулийн этгээдийн” гэж, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтын “21.1” гэснийг “26.1” гэж, 21 дүгээр зүйлийн 21.6 дахь хэсгийн “аж ахуйн нэгжийг бүртгэх эсэх талаар ажлын 10” гэснийг “хуулийн этгээдийг бүртгэх эсэх талаар ажлын 5” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.2, 16.2.4, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалтын “гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэх эсэх талаар ажлын 5 өдрийн дотор, бусад” гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

“44.5. Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдэд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 16.1.1-т заасан хугацаагаар газар ашиглуулах эрхийг олгоно.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГГИЙН ХУРААМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн 15.1.1-д "44 000" гэснийг "350 000" гэж, 15.3 дахь хэсгийн 15.3.2, 15.3.5-д "750 000" гэснийг "350 000" гэж, 15.3.3-д "35 000", 15.3.4-т "40 000" гэснийг "10 000" гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Цөмийн энергийн тухай хуулийн 30, 31 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай заалт нэмсүгэй.

“5<sup>1</sup>.6.Энэ хуулийн 5<sup>1</sup>.2-т заасан төлөвлөгөөг батлахдаа Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12.3-т заасныг баримтална.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлд дараах агуулга бүхий хэсэг нэмсүгэй.

“30.2.Хөрөнгө оруулах зорилгоор Монгол Улсад ирсэн гадаадын иргэнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.9-д заасан нээлттэй мэдээллийг үндэслэн гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага оршин суух зөвшөөрөл олгоно.”

**2 дугаар зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн дугаарыг “30.3” гэж, мөн хэсгийн “30.1-д” гэснийг “30.1, 30.2-т” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 30.1 дэх хэсгийн “Хөрөнгө оруулах,” , “хөрөнгө оруулалт,” гэснийг тус тус хассугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.6 дугаар заалтын “нэг зуун нэгжтэй” гэснийг “таван зуун нэгжтэй” гэж, 3.3 дахь заалтын “арван нэгжтэй” гэснийг “тавин нэгжтэй” гэж, тайлбар хэсгийн “хоёр мянган нэгжтэй” гэснийг “арван мянган нэгжтэй” гэж тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Аудитын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 16.2.6, 16.2.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Монгол Улсын аж ахуйн нэгж” гэснийг “хуулийн этгээдэд” гэж өөрчлөн найруулсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**УСНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Усны тухай 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Байгалийн ургамлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “дотоодын” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТАРИФ, ГААЛИЙН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн “Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11.2.1-11.2.3-т заасан салбарын” гэснийг “Барилгын материал, газрын тос, хөдөө аж ахуйн боловсруулах үйлдвэр, экспортын бүтээгдэхүүний үйлдвэр, нано, био, инновацийн технологи агуулсан бүтээгдэхүүний үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр болон төмөр зам барих зэрэг” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН ЭРХ ЗҮЙН  
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн "3.1.2" гэснийг "4.1.2" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 11.5 дахь хэсэг нэмсүгэй:

"11.5.Тогтворжуулах гэрчилгээ эзэмшигчийн тухайд тогтворжуулах гэрчилгээ хүчин төгөлдөр байх хугацаанд тогтворжуулсан хувь, хэмжээгээр албан татвар ногдуулна."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Барилгын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 5.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### ГАРЫН ҮСЭГ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРӨЛЖСӨН БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 17 дугаар зүйлийн 17.2.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**ГАРЫН ҮСЭГ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Дугаар...

Улаанбаатар  
хот

**Хуулийн хэрэгжилт хангуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Хөрөнгө оруулалтын тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай: Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай.

1.1.хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль ёсоор дайчлан авсан шийдвэрийн жагсаалтыг гаргаж, нөхөх олговрын хэмжээг тодорхойлох, нөхөх олговрыг олгох арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах;

1.2.хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх шийдвэрийн төслийг олон нийт болон оролцогч талын саналыг авч, нөхөх олговрын асуудал хөндөгдөх бол холбогдох асуудлыг төсөвт тусган шийдвэрлүүлсний үндсэн дээр хэлэлцүүлдэг байх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хороонд тус тус даалгасугай.

**ГАРЫН ҮСЭГ**



**ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН  
ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**2023 он**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН  
ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГАА**

**АГУУЛГА**

<b>ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....</b>	<b>3</b>
<b>ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....</b>	<b>4</b>
<b>НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ.....</b>	<b>5</b>
<b>1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар,     цар хүрээг тогтоох.....</b>	<b>10</b>
<b>1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг,     иргэдийг тодорхойлох .....</b>	<b>10</b>
<b>1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл .....</b>	<b>11</b>
<b>ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ .....</b>	<b>15</b>
<b>ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....</b>	<b>15</b>
<b>ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ .....</b>	<b>20</b>
<b>ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ .....</b>	<b>28</b>
<b>ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ .....</b>	<b>31</b>
<b>ДОЛОО. ЗӨВЛӨМЖ .....</b>	<b>36</b>

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

МУ	Монгол Улс
УИХ	Улсын Их Хурал
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНВУ	Бүгд Найрамдах Вьетнам Улс
БНЧУ	Бүгд Найрамдах Чех Улс
БНХАУ	Бүгд найрамдах Хятад Ард улс
БНКУ	Бүгд Найрамдах Казахстан Улс
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ҮХГ	Үндэсний хөгжлийн газар

## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2-т “эдийн засгийн аюулгүй байдал”-ын хүрээнд олон тулгуурт, оновчтой бүтэц бүхий, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг бүрдүүлж, эдийн засгийн бие даасан байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх бодлого баримтлах”-аар заасан бөгөөд 3.2.2-т “хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогын хүрээнд үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх”-ээр заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.21-д “Төсөв, мөнгө, зээл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлт болон бүтцийн өөрчлөлтийн ололтыг цаашид тогтвортой хадгална.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.2.3-т “гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ” гэж заасан.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн суурийг тэлэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг төр, хувийн хэвшлийн түншлэл болон хөрөнгө оруулалтын түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Хөрөнгө оруулалт татахад бодлого, эрх зүйн орчноо хөрөнгө оруулагчдад сурталчилан таниулах, зорилтот улс, бус нутаг, эдийн засгийн салбар, тэргүүлэх чиглэлээр нь хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл, арга хэмжээг санал болгох, сурталчлах, хөрөнгө оруулалт татах бизнес уулзалт, форум, арга хэмжээг зохион байгуулах ажлыг эрчимтэй зохион байгуулах, цаашлаад хөрөнгө оруулагчид Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нь шаардлагатай төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, мэдээллээр хангах, хууль тогтоомжид заасан дэмжлэг, урамшууллыг бодитоор үзүүлэх, эрх ашгийг хамгаалах, баталгаагаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Иймээс ч 2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хууль нь зорилгодоо хүрсэн эсэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг бүрэн хангасан эсэхэд

дүгнэлт өгөх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалж чадаж буй эсэхийг тогтоох зорилгоор энэхүү судалгааг хийнэ.

Иймд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлах хэрэгцээ шаардлага бий эсэхийг судлах шаардлагатай байна.

### **Судалгааны аргачлал**

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэв:

1. асуудалд дүн шинжилгээ хийх;
2. асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох;
3. тухайн асуудлуудыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгааг хийх;
7. зөвлөмж боловсруулах.

### **УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлагыг Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын<sup>1</sup> 2.1-т заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэлээ.

### **НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ**

Монгол Улс 1992 онд ардчилсан тогтолцоонд шилжиж Үндсэн хуулиа шинэчлэн баталсантай холбоотойгоор эрх зүйт төрийн үндсийг хуульчилж, төрийн эрх мэдлийн хуваарилалт хийж, шүүхийн бие даасан байдлыг хуульчлахын сацуу, хувийн өмчийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрх ашгийг хамгаалан, дэлхийн эдийн засгийн түгээмэл чиг хандлагад нийцүүлж эдийн засгаа удирдах, чөлөөт зах зээлийн зарчмыг нэвтрүүлснээр гадаадын хөрөнгө оруулалтыг татах эрх зүйн орчин бүрдсэн. Монгол Улсын Үндсэн хуулийн чиг хандлагад нийцүүлж анхны хөрөнгө оруулалтын хуулийг 1993 онд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай нэртэйгээр баталснаар Монгол Улс гадаад зах зээлд нээлттэй бодлогыг баримталж, улмаар гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ үнэмлэхүй өссөн байна. Эрдэс баялгийн бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн эрэлт хэрэгцээнээс шалтгаалж, Монгол Улс ч ашигт малтмал, газрын тосны салбарт хөрөнгө оруулалт татах бодлогыг хэрэгжүүлсэн нь улсын төсвийн орлогод ч нөлөөлөл үзүүлж Монгол Улс уул уурхайн салбараас өнөөдөр төсвийн орлогын 90 гаруй хувийг төвлөрүүлдэг болсон. Хөрөнгө оруулалтын хэмжээ уул уурхайгаас хамааралтай огцом өсөж байсан хугацаанд

<sup>1</sup> Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол. Нэгдүгээр хавсралт.

буюу 2012 онд Стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид гадаадын хөрөнгө оруулалтыг зохицуулах тухай хуулийг батлан гаргасан нь банк, хэвлэл мэдээлэл, уул уурхайн салбарт гадны төрийн өмчит компани хөрөнгө оруулах бол зөвшөөрөл авдаг байх асуудлыг хуульчилсан.

Эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад хөрөнгө оруулалтыг хадгалах бодлогыг баримтлах, татварын болон татварын бус дэмжлэгийг хөрөнгө оруулагч нарт үзүүлэх зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийг 2013 онд шинэчилсэн.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 2013 оны шинэчлэлээс хойш даруй 10 гаруй жил болж байгаа энэ хугацаанд хуульд нийт 11 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хуулийн хэрэгжилтийг дүгнэх, хуулиар хөрөнгө оруулалтыг татах, хамгаалах зорилгодоо хүрсэн эсэхийг дүгнэх зайлшгүй шаардлага үүсч байна. Тоон мэдээллээс үзэхэд хөрөнгө оруулалтын хэмжээ нь тодорхой шалтгааны улмаас уг хуулийн хэрэгжилтийн хугацаанд буурсан байгаа нь хуулийг хэрэгжилтэд бид дүгнэлт хийх цаг болсныг илтгэж байна. Тодруулбал:

Монгол Улсын гадаадын шууд хөрөнгө оруулалт 2000-2010 онд уул уурхай салбарын өсөлтийг дагаад жилд дунджаар 20-25 хувийн тогтмол өсөлттэй явж ирсэн боловч 2011 оноос хойш хийгдсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, уул уурхайн түүхий эдийн эрэлт, үнэ ханшны хэлбэлзлээс шалтгаалан өсч, буурсан үзүүлэлттэй явж ирсэн. /зураг 1/

Монгол Улсын хувьд төрөөс гарч байгаа зарим шийдвэрүүд хангалттай судалгаатай бус улмаар эрх ашиг нь хөндөгдөх этгээдээс санал аваагүй буюу сонсох ажиллагаа явуулаагүй зэргээс шалтгаалж хөрөнгө оруулагч нарын эрх ашгийг ноцтой хохироох тохиолдол их байна. Тухайлбал, газрыг тусгай хэрэгцээнд авах замаар ашигт малтмал, газрын тосны салбарт үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарладаг нь шууд бусаар тусгай зөвшөөрлийг албадан хурааж байгаа явдал юм. Гэвч энэхүү шийдвэрийг гаргахдаа эргээд төрөөс нөхөн төлбөрт хэдий хэмжээний төлбөр төлөх ёстой, хэзээ төлөх ёстой зэрэг асуудлыг шийдвэрлэхгүй байгаа нь хөрөнгө оруулагчдын нийтлэг баталгааг зөрчиж буй явдал юм.

Дэлхийн зах зээл дээрх эрдсийн түүхий эдийн ханшийн уналтаас шалтгаалан гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан гэж дүгнэж болно

Дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн ханшийн уналт болон бусад шалтгааны улмаас 2011 онд 5.0 тэрбум ам.долларт хүрч байсан Монгол Улс дахь гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом буурч 2015 онд 1.4 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд 2016 оноос сэргэж 2019 оны жилийн эцэст 3.1 тэрбум ам.долларт хүрсэн. Гэвч Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үр нөлөөгөөр 2020 оны жилийн эцэст өмнөх оноос 22.8 хувиар буурч 2.5 тэрбум ам.доллар болсон байна.

Иймээс урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан, гадаадын шууд хөрөнгө оруулалтын орчинд хэлбэлзлийг сааруулсан бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага үүсээд байна.


Зураг 1. Гадаадын шууд хөрөнгө оруулалт



Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам, 2023.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 70 гаруй хувь нь зөвхөн уул уурхайн салбарт хийгдэж, аж үйлдвэр, үйлчилгээ, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт маш бага хувийг эзэлж байна. Манай улсын хувьд уул уурхайн салбараас хэт хамааралтай байдал нь эдийн засгийг тогтвортой өсөх боломжийг сааруулж, хэмжээний хувьд түүхий эдийн үнэ ханшийн өөрчлөлтөөс хамаарах нь урт хугацааны төлөвлөлт хийхэд төвөгтэй байдлыг үүсгэж иржээ.

Зураг 2. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (салбараар)



Эх сурвалж: Эдийн засаг, хөгжлийн яам, 2023

Эдийн засгийн төрөлжүүлэлт: Монгол Улсад 1990 оноос хойш нийт 35.6 тэрбум ам.долларын гадаадын шууд хөрөнгө оруулалт орж ирсэн бөгөөд түүний 72 хувь нь геологи, уул уурхайн эрэл хайгуул, олборлолт, газрын тосны салбарт, 11 хувь нь бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт, харин бусад салбар нийлээд 17 хувийг эзэлж байна. Бусад салбарын хөрөнгө оруулалт нийт хөрөнгө оруулалтын хэмжээнд маш бага хувийг эзэлж байгаа нь гадаадын хөрөнгө оруулалт төрөлжихгүй, зөвхөн дээрх 2 салбарт харьцангуй ялгамжтай төвлөрч байгааг харуулж байна.

Дэлхий дахинаа 2020 оны 1 дүгээр сараас эхлэн коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нөлөөгөөр улс орнуудын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч, 2020 онд цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын эдийн засаг 5.3 хувиар агшиж, гадаадын шууд хөрөнгө оруулалт 18.2 хувиар буурсан байна. Гадны улс орон бүр цар тахлын дараах сэргэлтэд бэлтгэж буй энэ цаг үед Монгол Улс ч мөн өөрийн гэсэн орон зайгаа тэлэх боломжийг эрэлхийлэх нь зүйтэй юм.

Шинэ тутам гарч ирж буй зах зээлийг хэрхэн ашиглаж, хөрөнгө оруулалт татах боломж болгон хувиргах, шинээр Монголыг зорьж буй хөрөнгө оруулагчдад үзүүлэх дэмжлэгийг салбар бүрт тодорхой болгох, өртөг нь нэмэгдэж буй нүүрсний төслүүдийн санхүүжилтээс ногоон зах зээл рүү шилжих гэх мэтчилэн анхаарах олон нөхцөлүүд үүсэн буйг анхаарах шаардлага тулгарч байна.

Коронавируст халдвар /КОВИД-19/-т цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн суурийг тэлэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг төр, хувийн хэвшлийн түншлэл болон хөрөнгө оруулалтын түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэхээр тусгагдсан.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 100 их наяд төгрөгийн 94 хөгжлийн төсөл байгаагаас санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй 70 төсөл байна. Үүнээс 36 их наяд төгрөгийг төр, хувийн хэвшлийн түншлэл, хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр төлөвлөсөн бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтыг оролцуулвал нийт 72 их наяд төгрөг шаардлагатай байна.

Эдгээр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улс орон бүрийг онилсон хөрөнгө оруулалтын тухайлсан стратеги боловсруулж, хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээг нэгдсэн байдлаар хүргэж, дэмжиж ажиллах шаардлага бий болоод байна.

Мөн Монгол Улсад оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, дээрх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийн тулд хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлага үүссэн. Тухайлбал хөрөнгө оруулагчдын зүгээс Монгол Улсад хөрөнгө оруулахад хууль эрх зүй тогтворгүй бөгөөд тодорхойгүй байдал, тэдний эрх ашгийг хамгаалах механизм бодитой бүрдээгүй, хөрөнгө оруулалттай холбоотой асуудалд ялгавартай хандах хандлага байна гэж үзэж байгаа тул хөрөнгө оруулах сонирхол нь төдийлөн нэмэгдэхгүй байна.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 37 дугаар тогтоолоор байгуулагдсан хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын бүрэн эрхийн талаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгаж өгөөгүй байна. Иймд тус байгууллагын бүрэн эрх, чиг үүргийг Хөрөнгө оруулалтын тухай хуульд бусад байгууллагын бүрэн эрх, чиг үүрэгтэй давхардуулалгүйгээр нарийвчлан тусгаж өгөх шаардлага байна.

Төрийн институцийн өөрчлөлтийн үр дагаврын нөлөөгөөр Монгол Улсын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сүүлийн хорин жилийн турш байнга өөрчлөгдөж, институцийн хувьд тогтворгүй байдалтай ажилласаар ирсэн. /хүснэгт 1/

Хүснэгт 1. Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан байгууллага

№	Байгууллага	Хугацаа	Чиг үүрэг
1	Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг	1996-2012	- гадаад худалдаа болон ГШХО-тай холбоотой асуудлыг бүхэлд нь хариуцах
2	Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газар	2012-2013	- гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалтай холбоотой асуудлыг цогцоор нь хариуцах, гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн чиг үүргээс экспорт болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжих чиг үүрэг нь Эдийн засгийн хөгжлийн яаманд шилжсэн.
3	Инвест Монголиа агентлаг (Хөрөнгө оруулалтын газар)	2013-2016	- хөрөнгө оруулалтыг дэмжих, зохицуулахын зэрэгцээ татварын тогтворжуулах гэрчилгээ олгох, гэрчилгээ эзэмшигч нарын үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлсэн.
4	Үндэсний хөгжлийн газар (Хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлтийн газар)	2016-2021	- хөрөнгө оруулалтын цогц бодлогыг тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулалтын холбогдох бодлого, зохицуулалтыг тодорхойлон уялдааг хангах, концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой бодлого боловсруулах
5	Эдийн засаг, хөгжлийн яам (Хөрөнгө оруулалтын бодлогын газар)	2022 оноос	- хөрөнгө оруулалтын цогц бодлогыг тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулалтын холбогдох бодлого, зохицуулалтыг тодорхойлон уялдааг хангах, концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой бодлогыг боловсруулах

## **1.1. Асуудлыг тодорхойлж шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоох**

Дээр дурдсан нөхцөл байдлыг дүгнэж үзвэл дараах асуудал голлон анхаарал татаж байна. Үүнд:

Нэгдүгээрт, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах хэрэгцээ шаардлага нь хөрөнгө оруулалтын талаар эрх зүйн орчин тогтворгүй, гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах механизм бодитой бүрдээгүй, хөрөнгө оруулалттай холбоотой асуудалд үл ялгаварлах зарчмыг хуульд тусгаагүй байдлаас бий болж байна.

Хоёрдугаарт, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах хэрэгцээ шаардлага нь өнгөрсөн хугацаанд Монгол Улсад хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа тогтворгүй явж ирснээс залгамж халаа алдагдсан, үүнтэй холбоотойгоор хөрөнгө оруулагчдад ойлгомжгүй байдал бий болсон, мөн тус байгууллагын бүрэн эрхийн талаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд тусгаагүй байдлаас бий болж байна.

Гуравдугаарт, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах хэрэгцээ шаардлага нь хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгохоор шийдвэрлэсэн бол хөрөнгө оруулалтаа хийж буй эсэхэд хяналт тавих, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа хэвийн явуулахад зөвлөмж, чиглэл өгөх талаар зохицуулалт дутмаг байгаагаас бий болж байна.

Дөрөвдүгээрт, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах хэрэгцээ шаардлага нь хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийн талаар хуульд нарийвчлан тодорхойлоогүй, хэрэгжих бодит нөхцөл Хөрөнгө оруулалтын тухай болон бусад салбарын хуульд бүрэн тусгаагүй байдлаас бий болж байна.

Тус асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг сайжруулах цар хүрээг “Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлах” гэж тодорхойлов.

## **1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох<sup>2</sup>**

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

---

<sup>2</sup> Аргачлалын 3.1.2-т “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор заасан байдаг. Энэхүү судалгааны хүрээнд хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг эрх ашиг нь хөндөгдөх бүлгээр тодорхойлсон тул дээрх бүгд хамаарна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг	Нөлөөлж буй хэлбэр
1. Хөрөнгө оруулагч хувь хүн/Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн/	Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин, тэдэнд олгох татварын болон татварын бус дэмжлэг туслалцаа үзүүлэх асуудал хуульд тодорхой тусгагдаагүйгээс тэдний эрх ашиг зөрчигдөх, эрх ашиг нь зөрчигдсэн тохиолдолд хамгаалах механизм байхгүйгээс цаг хугацаа, хөрөнгө мөнгөний хувьд хохирох тохиолдол бий болдог.
2. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, Монгол Улсын хуулийн этгээд	Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн тодорхойлолтын талаар хуульд оновчтой тодорхойлоогүй байдал нь тус аж ахуйн нэгжид хөрөнгө оруулсан дотоодын иргэн, аж ахуйн нэгжийн эдлэх эрхэд хязгаарлалт тогтоох, эрх ашгийг зөрчих эрсдэлтэй.

Эрх ашиг нь хөндөгдөж, нөлөөлөл үзүүлэх бүлгийн хувьд хөрөнгө оруулалтын харилцаанд оролцогч нь Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаад улсад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж бүгд хамаарахаар байна. Учир нь Хөрөнгө оруулалтын тухай хуульд заасан зохицуулалт, түүнийг хэрэгжүүлэх ажиллагаанаас тус хүмүүсийн эрх зүйн байдал, эрх ашиг шууд хамаардаг.

### 1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Хөрөнгө оруулалтын тухай хуульд институцийн өөрчлөлттэй холбоотой оруулсан удаа дараагийн нэмэлт, өөрчлөлтөөс харахад хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлж, эдийн засгийн өсөлтийг хангахад сөрөг үр дагавар үүсгэсэн.

Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг нь 1996 онд гадаад худалдаа болон гадаадын шууд хөрөнгө оруулалттай холбоотой асуудлыг хариуцах чиг үүрэгтэйгээр байгуулагдсан. Тус агентлаг нь эхэн үедээ (i) хөрөнгө оруулалтыг дэмжих болон (ii) бүртгэл, зөвлөх үйлчилгээ гэсэн үндсэн хоёр газартай байсан ба үйл ажиллагааны 50 хувь нь бүртгэл, зөвлөх үйлчилгээнд чиглэгдэж байв.

Тухайн үед Монгол Улсад гадаадын шууд хөрөнгө оруулалт татах үйл явц нь харьцангуй шинэ үйл ажиллагаа байсан тул нэг талаасаа нээлттэй буюу бүх салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа явуулж байсны зэрэгцээ тодорхой тэргүүлэх салбар, чиглэлүүдэд хөрөнгө оруулалтыг дэмжих, татах, эдийн засгийг төрөлжүүлэх үүднээс Засгийн газраас хөнгөлөлт, чөлөөлөлтийн дэмжлэгүүдийг үзүүлдэг байсан. Гэвч тухайн үед агентлаг нь хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн тодорхой бодлого, стратеги чиглэлгүй байсны зэрэгцээ гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татсанаар эдийн засгийн хөгжил, ажлын байр

нэмэгдүүлэхэд эерэг нөлөөтэй гэсэн ерөнхий ойлголтоос давсан нэгдсэн, ойлгомжтой тодорхойлолт байхгүй байв.

Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг нь Монгол Улсыг гадаадад сурталчлах олон улсын болон дотоодын хэвлэл мэдээллийнхэнтэй хамтарч ажиллах, гадаад, дотоодод хоёр талт болон олон талт бизнес форум, чуулга уулзалт, семинар, үзэсгэлэн, гадаад, дотоодын төлөөлөгчдийн айлчлал, албан болон бизнесийн уулзалтууд зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжин сурталчлах ажлуудыг тогтмол зохион байгуулж байсан байна.

Хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулагчийг бүртгэх үйл ажиллагаанаас гадна бүртгэлийн өмнөх болон дараах зөвлөх үйлчилгээ, хөрөнгө оруулагчдыг маргаантай асуудал дээр хамгаалсан тодорхой хэмжээний хөрөнгө оруулалтын дараах үйлчилгээг хамруулдаг байв. 2012 онд Улсын Их Хурлын сонгуулийн дараа Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн чиг үүрэг, статусыг өөрчлөн шинээр байгуулагдсан Эдийн засгийн хөгжлийн яамны харьяа Гадаадын хөрөнгө оруулалтын зохицуулалт, бүртгэлийн газарт шилжсэн. Мөн Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн чиг үүрэгт хамаарч байсан экспорт болон жижиг, дунд үйлдвэрийг дэмжих чиг үүрэг бусад байгууллагад шилжсэн юм.

Хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагийн статус нь Эдийн засгийн хөгжлийн яамны бүтцийн нэгж болон өөрчлөгдөж, хөрөнгө оруулалтыг дэмжихтэй холбоотой чиг үүрэгт өөрчлөлт бараг ороогүй боловч хөрөнгө оруулалтыг дэмжих, татах тал дээр идэвхгүй байр суурьтай болоход нөлөөлсөн. Түүнчлэн хөрөнгө оруулалтыг дэмжих үйл ажиллагаа Улсын бүртгэлийн ерөнхий газрын Гадаад хуулийн этгээдийн бүртгэлийн газарт шилжүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжихтэй холбоотой үйл ажиллагааг хөрөнгө оруулалтыг бүртгэхээр хязгаарлагдах болсон.

2013 онд сүүлээр батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтыг дэмжих шинэ байгууллага буюу “Инвест Монголиа” агентлаг (Хөрөнгө оруулалтын газар)-ийг Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх асуудлын хүрээнд байгуулсан. Тус агентлаг нь хөрөнгө оруулалтыг дэмжих, зохицуулахын зэрэгцээ татварын тогтворжуулах гэрчилгээ олгох, гэрчилгээ эзэмшигч нарын үйл ажиллагааг хянах үүргийг давхар гүйцэтгэж байв.

Хөрөнгө оруулалтын бодлого, дэмжлэгийн асуудал хариуцсан байгууллагын бүтэц, зохион байгуулалтад дахин өөрчлөлт орж 2016 онд Хөрөнгө оруулалтын газрын чиг үүргийг Үндэсний хөгжлийн газарт нэгтгэн шилжүүлсэн. Тус газар нь өргөн хүрээний олон талын чиг үүрэг бүхий газар болон өргөжсөн боловч хөрөнгө оруулалтын асуудлын хүрээнд үндэсний хөгжлийн цогц бодлогыг боловсруулах, тэргүүлэх салбаруудыг тодорхойлох, салбарууд болон дэд бүтцийн хоорондох зохистой харьцааг хадгалах, хөрөнгө оруулалтын цогц бодлогыг тодорхойлох, гадаадын хөрөнгө оруулалтын холбогдох бодлого, зохицуулалтыг тодорхойлон уялдааг хангах, концесс болон төр, хувийн хэвшлийн түншлэлтэй холбоотой бодлогыг боловсруулах, томоохон хэмжээний төсөл, хөтөлбөрийн техник, эдийн

засгийн үндэслэлийг боловсруулах, түүнчлэн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд санал өгөх зэрэг чиг үүрэг хэрэгжүүлж ажилласан.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээг тодорхойлсон боловч хөрөнгө оруулалтын дараах үйл ажиллагааны дэмжлэг орхигдсон, төрийн байгууллага, бүтцийн эрх хэмжээг нарийвчилан зохицуулаагүй тул хуулийн хэрэгжилт орхигдох, хэрэгжилтэд тодорхойгүй байдал үүсэх нөхцөл хөрөнгө оруулагчдад үүссэн.

Өмнө нь Хөрөнгө оруулалтын газрын 8 ажилтан хөрөнгө оруулалтыг дэмжих, сурталчлах чиглэлээр ажилладаг байсан бол Үндэсний хөгжлийн газарт дээрх чиглэлээр 5 албан хаагч хариуцаж, хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлийн үйл ажиллагаа гэхээс илүүтэйгээр олон нийттэй харилцах, тус газрын сурталчилгааны ажлуудыг хийхэд чиглэсэн. Хөрөнгө оруулалтын чиглэлээр холбогдох төрийн захиргааны төв (Гадаад харилцааны яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам) болон төрийн захиргааны байгууллагын зүгээс хөрөнгө оруулалтыг дэмжих болон хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа явуулах чадавх боломж бололцоо мөн бага тул манай улсын хөрөнгө оруулалтыг дэмжих чадавх, бүтэц ихээхэн суларсан байна.

Мөн аж ахуйн нэгжийг гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэлбэрээр ялгаварласан, үйл ажиллагаа явуулахыг хориглосон, хязгаарласан зохицуулалт болон төрийн үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, хүсэлтээ шийдвэрлүүлэх хугацаа, төлбөр хураамжийг ялгамжтай тогтоосноос шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжүүд хараат болон охин компани, компанийн нэгдлийг байгуулж байгаа нь гадаадын шууд хөрөнгө оруулалтыг бодит үр өгөөжийг тодорхойлох, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогыг тодорхойлоход хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байна.

Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах, хөрөнгө оруулагчийг зах зээлийн судалгаа, мэдээллээр хангах замаар хөрөнгө оруулалт татах, шинээр хөрөнгө оруулалт орж ирэх үеийн бүртгэл, тусгай зөвшөөрөл авах үйл ажиллагаа боловсронгуй бус байгаа нь хөрөнгө оруулагчдыг татахад хүндрэл учруулж, улмаар Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна" гэх төрийн үндсэн үүргийг хангалттай түвшинд хэрэгжүүлэх боломжийг хааж байна.

Хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлж буй бас нэг томоохон хүчин зүйл нь төрийн шийдвэр гаргалттай холбоотой үйл явц юм. Монгол Улс хуулийн хэрэгжилтийг хангах, асуудлыг шийдвэрлэх талаарх болон эрх ашиг нь хөндөгдөх этгээдэд сонсох ажиллагааг хангалттай хийдгүйгээс хөрөнгө оруулагч нарт асар их зардал чирэгдэл учирч байна. Иймээс хөрөнгө оруулагч нарын зүгээс аливаа эрх ашигт нь хамаарах бодлогын шийдвэрийн талаар мэдэх эрхийг хангах, саналаа өгөх боломжийг бүрдүүлдэг байх нь чухал юм. Хэдийгээр Хууль тогтоомжийн тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд энэ талаар тусгасан ч хуулийн хэрэгжилтийг хангахгүй байх хязгаарлалтын заалтууд холбогдох хуулиудад байна.

Түүнчлэн хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль ёсоор албадан хураан авахтай холбоотой нэгдсэн зарчмыг тодорхойлоогүй нь төрийн байгууллагаас гаргах шийдвэр нь дураар аашлах нөхцөл байдлыг бий болгох эрсдэлтэй бөгөөд хуулийг дураар тайлбарлах ч эрсдэл үүсгэж байна. Иймээс хөрөнгийг хураан авах зохицуулалтын үр дүнд хөрөнгө оруулагчид олгох нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлох нөхцөлийг хуульчлах нь зүйтэй байна.

Улмаар төрийн байгууллага, албан хаагчийн хууль бус үйл ажиллагаатай холбоотойгоор хөрөнгө оруулагчийн эрх ашиг хохирох тохиолдолд нэн тэргүүнд эвийн журмаар гомдлыг шийдвэрлэх боломжийг бүрдүүлэх нь зүйтэй байна. Энэ ч агуулгаар төрийн албан хаагчийн буруутай үйлдэлтэй холбоотой мэдээллийг нэгтгэн, гүйцэтгэх засгийн түвшинд асуудлыг сонсож, чиглүүлэх шийдлийг бий болгох нь зүйтэй байна.

Түүнчлэн хөрөнгө оруулалтын үе шатад тогтвортой байдлыг хангах, үйл ажиллагаа шуурхай явуулах нөхцөлөөр хангах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, гомдол маргаан шийдвэрлүүлэх тогтолцоог боловсронгуй байдлаар бий болгоогүй нь хөрөнгө оруулагчдын Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхол, итгэл үнэмшлийг бууруулж байна.

Тухайлбал, Монгол Улсад хөрөнгө оруулалтын асуудлаар үүссэн 6 арбитрын маргаан байна.

	Эхэлсэн, шийдвэрлэсэн хугацаа	Маргаан	Хамаарах хууль	Шийдвэрлэсэн байдал	Салбар
1.	2004	Алстом /Итали/	Эрчим хүчний харти, ХОХДХХТХ /BIT/	Эвлэрсэн.	Эрчим хүч
2.	2007-2011	Сергей Паушок /ОХУ/	ХОХДХХТХ /BIT/	Монгол Улсын талд шийдвэр гарсан	Уул уурхай
3.	2010-2017	Чайна Хэйлонгжин /БНХАУ/	ХОХДХХТХ /BIT/	Монгол Улсын талд шийдвэр гарсан	Уул уурхай
4.	2011-2015	Хан ресурс /Канад, Нидерланд, Виржиний арлууд/	Олон Улсын эрчим хүчний харти	Хөрөнгө оруулагчийн талд шийдсэн /80 сая ам.дол/	Уул уурхай
5.	2018	Mohammed Munshi Gobi Coal & Energy Ltd	Олон Улсын эрчим хүчний харти	Хүлээгдэж байгаа	Уул уурхай
6.	2021	WM Mining v. Mongolia /Их тохойрол ХХК/	ХОХДХХТХ /BIT/	Хүлээгдэж байгаа	Уул уурхай

Эх сурвалж: [Investmentpolicy.unctad.org](http://Investmentpolicy.unctad.org)

Эдгээр асуудлын шалтгаан нөхцөл нь дээрх асуудлуудад үндэслэсэн Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т “Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно”, уг зорилгыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд “1.гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна”, мөн “Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна”, мөн ““Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 4.3.12-т “Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зохицуулалтын орчныг сайжруулна” гэсэн зорилтод чиглэх бөгөөд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулах шалтгаан, нөхцөл болж байна.

## **ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ**

Шийдвэрлэх зорилгын тухайд өмнөх шатанд хийсэн дүгнэлтэд үндэслэн дараах шийдвэрлэх зорилгыг тодорхойлж байна.

Зорилго: “Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах замаар хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон холбогдох бусад байгууллагын чиг үүргийг тодорхой болгож, зааг ялгааг нарийвчлан тогтоох, хуульд заасан ойлголт, нэр томьёо түүнээс үүдэн гарах ойлгомжгүй байдлыг арилгах, хөрөнгө оруулалтын дэмжлэг, тусламжийн асуудлыг оновчтой байдлаар зохицуулах, хөрөнгө оруулагчдын хууль ёсны эрх, ашиг, сонихрлыг хамгаалах үр дүнтэй механизмыг бий болгоход оршино”.

Дээрх зорилгын хүрээнд Монгол Улсад хөрөнгө оруулахад хөрөнгө оруулагчдад хүндрэл бэрхшээл үүсч байгаа эсэх, үүнийг хөрөнгө оруулалтын дэмжлэг, тусламжтой холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах бодитой механикмыг бий болгох замаар шийдвэрлэж болох эсэх, Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулах хууль, эрх зүйн шаардлага бий эсэх, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлон тусгах шаардлагатай эсэх гэсэн зорилтуудыг томъёолсон болно.

## **ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

“Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын 5.1-т заасан зохицуулалтын хувилбаруудын дагуу асуудлыг зохицуулах хувилбарыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан хүснэгт 2-т харуулав.

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
----------	-----------------------	-----------------------------	--------

“тэг” хувилбар	Хөрөнгө оруулалтын хуулийн хэрэгжилт хангалтгүй, олон улсын байгууллагаас хийсэн судалгааны үр дүн хангалтгүй байгаа тул өнөөгийн тулгамдаж буй байдал хэвээр үргэлжлэх тул зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй ч сөрөг үр дагавар улам бүр нэмэгдэнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх;	Тус хувилбарыг хэрэгжүүлснээр асуудлууд шийдвэрлэгдэхгүй хэвээр үргэлжлэх тул зорилгод хүрэх боломжгүй.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар үргэжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Одоо тулгамдаж буй асуудлууд нь татвар хураамжийн бодлого, тусгай зөвшөөрөл зэргээр тодорхой хязгаарлалт тогтоож өгөх зэргээр арга хэмжээг авч хэрэгжүүлснээр зорилгод хүрч чадахгүй байна.	Тодорхой хэмжээнд зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
төрөөс санхүүгийн интервенц хийх	Одоо тулгамдаж буй асуудлуудыг төрөөс шууд мөнгөн хэлбэрийн санхүүжилт үзүүлэх замаар шийдвэрлэхэд тохиромжгүй тул тус хувилбар зорилгод хүрч чадахгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Хөрөнгө оруулалтын асуудал нь нь өргөн цар хүрээ, олон салбарыг хамардаг бөгөөд нэгдсэн бодлогын дагуу төрийн холбогдох байгууллагууд хувийн хэвшилтэй харилцан уялдаатай хамтран ажиллах шаардлагатай бөгөөд уг харилцааг нарийвчлан зохицуулж тодорхой болголгүйгээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлснээр асуудлыг шийдвэрлэх боломжгүй байна.	Төрөөс зардал гарах бөгөөд асуудлыг шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.
захиргааны шийдвэр гаргах	Хуулиар зохицуулагдаагүй зарим харилцааг тус хувилбарын дагуу захиргааны шийдвэр гарган хэрэгжүүлэх боломжгүй байна. Тус хувилбар нь асуудлыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна.	Асуудлыг үүсгэж байгаа зарим шалтгааныг арилгах боломжтой ба тулгарч буй бэрхшээлийг бүрэн шийдвэрлэхгүй тул сөрөг үр дагавар хэвээр үргэжилнэ.	Сөрөг үр дүнтэй байна.

хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хөрөнгө оруулалтыг татах, дэмжих, сурталчлах асуудлыг цогцоор авч үзэх шаардлагатай тул тус хувилбар нь зорилгодоо хүрэх бүрэн боломжтой байна.	Зардал гарахгүй бөгөөд одоо үүсээд байгаа тулгамдсан асуудлуудын шалтгаан, сөрөг үр дагавар арилна. Төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхой болно.	Үр дүн зэрэг байна.
---	---	--	---------------------

Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх замаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй.

Дээрхээс дүгнэвэл асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн “Монгол Улсад хөрөнгө оруулахад хөрөнгө оруулагчдад хүндрэл бэрхшээл үүсч байгаа эсэх, үүнийг хөрөнгө оруулалтын дэмжлэг, тусламцаа үзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгуй болгох, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах бодитой механизмыг бий болгох замаар шийдвэрлэж болох эсэх, хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулах хууль, эрх зүйн шаардлага бий эсэх, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлон тусгах шаардлагатай эсэх” гэсэн зорилгод хүрэхийн тулд одоо байгаа тогтолцооны хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчилэн боловсруулж, батлах нь зүйтэй гэж үзлээ.

Үүнээс гадна захиргааны шийдвэр гаргах ажиллагаа нь зарим нэг зорилтыг хангах боломжтой боловч тулгамдаж буй асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй бөгөөд үр дүн муутай болох нь харагдаж байна.

Иймд “Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах замаар хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон холбогдох бусад байгууллагын чиг үүргийг тодорхой болгож, зааг ялгааг нарийвчлан тогтоох, хуульд заасан ойлголт, нэр томьёо түүнээс үүдэн гарах ойлгомжгүй байдлыг арилгах, хөрөнгө оруулалтын дэмжлэг, тусламжийн асуудлыг оновчтой байдлаар зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үр дүнтэй механизмыг бий болгох” зорилгын хүрээнд дараах хувилбаруудыг дэвшүүлж байна.

*Хувилбар 1.* Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах замаар Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох.

*Хувилбар 2.* Хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамждаж буй асуудлыг захиргааны шийдвэр буюу захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар зохицуулах.

Нэгдүгээр хувилбарын хувьд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, батлах замаар хөрөнгө оруулагчдад тулгарч буй асуудал болох тогтворгүй бөгөөд ойлгомжгүй байдал, хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй төрийн байгууллагуудын чиг үүргийн давхардал болон чиг үүрэг тусгагдаагүй байдал, хөрөнгө оруулагчдын Монгол Улсад хөрөнгө оруулах санал, уриалгад үл итгэх, болгоомжлох хандлагыг бүрэн арилгах боломжийг олгоно.

Хоёрдугаар хувилбар нь захиргааны шийдвэр буюу захиргааны акт захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар дээр дурдсан асуудлаас зарим асуудлыг шийдвэрлэх боломж олгохоор байна. Тухайлбал, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах үйл ажиллагааны журмыг баталж, тус журам заасны дагуу хөрөнгө оруулагчдыг эрх ашиг зөрчигдсөн зарим нэг тохиолдлыг шийдвэрлэж болох талтай байна.

Дээрх хоёр хувилбар нь судалгаагаар дэвшүүлсэн зорилгод тодорхой хэмжээгээр хүрэх боломжтой гэж үзэж тус хоёр хувилбарын үр нөлөөг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаагаар харьцуулан авч үзье.

### **Хувилбар 1. Томьёолол**

“Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах замаар Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох.”

#### **Зорилгод хүрэх байдал:**

Асуудлыг шийдвэрлэх зорилт нь хөрөнгө оруулалтын хууль тогтоомжийн уялдаа холбоогүй, зарим зохицуулалт нь практикт хэрэгжих боломжгүй байдал, үүнээс үүдэн хөрөнгө оруулагчдын эрх ашиг зөрчигдөж, Монгол Улсад хөрөнгө оруулах сонирхол багасч буй нөхцөл байдлыг Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчлэн боловсруулж батласанаар арилгах явдал юм.

Хувилбар 1-ийн хувьд хуулийг шинэчлэн боловсруулж, батлах замаар зорилгод бүрэн хүрэх боломжтой хувилбар гэж үзэж байна. Учир нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчлэн боловсруулж, баталж тулгарч буй асуудлыг зохицуулах нь дараах ач холбогдолтой байна.

1. Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, төрийн захиргааны төв байгууллагын төвлөрсөн эрх үүргийг зааглаж, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, бодлого төлөвлөлт, хууль тогтоомжийн хэрэгжилтийг улс, салбар, салбар хооронд болон бүс, орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх боломж бүрдэнэ;

2. Хөрөнгө оруулалт татахад тулгардаг тодорхойгүй, таагүй нөхцөл байдал, ач холбогдолгүй шаардлагууд арилж, хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдэх,

гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах, дахин хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх нөхцөл бүрдэнэ;

3. Хөрөнгө оруулалтын үр өгөөж нэмэгдэж, эдийн засгийг сэргээх, Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангах, хөгжлийн бодлогын хэрэгжилтийг хангагдаж дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдэнэ;

4. Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах үр дүнтэй механизм бүрдэж, хөрөнгө оруулалтын чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалтыг тогтвортой нэмэгдүүлэх боломж бүрдэнэ;

5. Хөрөнгө оруулалт эрэлхийлсэн, санхүүгийн эх үүсвэр шийдвэрлэгдээгүй төслүүдийг сонгон шалгаруулж, төслийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, төслийн бэлэн байдлыг хангаж, чадавхжуулах үйл ажиллагааг цогц байдлаар хэрэгжинэ;

6. Хөрөнгө оруулагчдад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд болон хөрөнгө оруулалтын төлөвлөлт хийхэд нь дэмжлэг үйлчилгээ үзүүлэх төрийн үйлчилгээний чанар сайжирна.

#### **Зардал, үр өгөөжийн харьцаа:**

Дээрх байдлаар Хөрөнгө оруулалтын тухай хуулийг шинэчилсэн тохиолдолд Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх сонирхолтой хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдэх, улмаар цар тахлын дараах эдийн засгийг сэргээх, тэлэх ач холбогдолтой байна. Харин зардлын хувьд хөрөнгө оруулалтын оролцож буй төрийн байгууллагуудад шинээр нэгж үүсэх, орон тоо нэмэх шаардлага үүсэхгүй тул улсын төсвөөс нэмэлт зардал гарахааргүй байна.

Иймд хуулийн төсөл батлагдсан гарснаар Монгол Улсын эдийн засагт эерэг нөлөөлөл үзүүлэх ба нэмэлт зардал гарахааргүй байгаа тул зардал, үр өгөөжийн харьцааны хувьд Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь илүү өгөөжтэй байна.

#### **Хувилбар 2. Томьёолол**

“Хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамдаж буй асуудлыг захиргааны шийдвэр буюу захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар зохицуулах.”

#### **Зорилгод хүрэх байдал:**

Энэхүү хувилбарын хувьд өмнөх хувилбартай харьцуулбал захиргааны шийдвэр буюу захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар тулгарч буй зарим саад бэрхшээлийг зохицуулах гэдгээрээ ялгаатай байна.

Захиргааны акт гэдэг нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны байгууллагаас тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгодог.

Захиргааны актаар хөрөнгө оруулагчдад тулгарч буй тодорхой нэг тохиолдлыг буюу явцуу хүрээнд шийдвэрлэх боломжтой. Харин захиргааны хэм хэмжээний тухайд заавал нийтээр дагаж мөрдөгддөг хэм хэмжээ байх хэдий ч хуулиар эрх олгогдсон хүрээнд л тулгарч буй асуудлыг шийдвэрлэх боломжтой. Бидэнд тулгарч буй асуудлын хүрээнд хууль эрх зүйн тодорхой бус бөгөөд зорилгодоо хүрч чадаагүй, зарим зохицуулалт тусгагдаагүй зэрэг нөхцөл байдал хамаарч байгаа болно. Иймд захиргааны шийдвэр буюу захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар асуудлыг бүрэн шийдвэрлэх боломжгүй үлдэх сул талтай байна.

### **Зардал, үр өгөөжийн харьцаа:**

Зардлын хувьд өмнөх хувилбартай адил хэдий ч өмнө дурдсанаар үр, өгөөж муутай байна.

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбар нь бага зардлаар өндөр үр дүнд хүрэхээр байна.

### **ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ**

Хууль тогтоомжийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг Аргачлалын 6-д заасны дагуу тандан судлалаа.

#### **1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө**

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхтэй холбоотой болон хүнийг эрхийг зөрчих магадлалтай зохицуулалт байхгүй болно.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	
	1.1.3.Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	
	1.2.Оролцоог хангах			
1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг хангах нөхцөлийг	

				нэмэгдүүлэхэд дэмжсэн зохицуулалт хийнэ.
	1.2.2.Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг хангах нөхцөлийг нэмэгдүүлэхэд дэмжсэн зохицуулалт хийнэ.
1.3.Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага				
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг хангах нөхцөлийг нэмэгдүүлэхэд дэмжсэн зохицуулалт хийнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмийн талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт хийгдэхгүй.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Тийм зохицуулалт хийгдэхгүй.
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт хийгдэхгүй.
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт хийгдэхгүй.
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Эрх зүйн зохицуулалт нь холбогдох бүлэг, эрх агуулагчдад эрх тэгш үйлчлэх

				тул тусгайлсан зохицуулалт шаардлагагүй.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Тусгайлсан зохицуулалт шаардлагагүй.
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Тийм	Үгүй	Тусгайлсан зохицуулалт шаардлагагүй.
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Ялгаатай тусгах зохицуулалт байхгүй.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Ялгаатай тусгах зохицуулалт байхгүй.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	

## 2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Дотоодын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн өрсөлдөх чадвар нэмэгдэнэ
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.

тогтвортой байдал	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй. Одоо байгаа зохицуулалтыг сайжруулж, тодорхой болгож өгнө.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулалтын нэмэгдүүлснээр, тус асуудлыг дэмжихэд шууд бусаар эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулалт нэмэгдснээр орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах нөхцөл бүрдэнэ.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зэрэг нөлөөлөл үзүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсөвт зэрэгээр нөлөөлнө.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу хэрэгжүүлэгч агентлагтай болно
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлээр чиг үүргийг тодорхой болгоно.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тус асуудалд зэрэг нөлөөлөл үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулагчдын татах нөхцөл бүрдэнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.

11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй. Олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжид нийцсэн.
------------------------	--	------	------	---

### 3. Нийгэмд үзүүлэх нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Хөрөнгө оруулалт нэмэгдэж, ажлын байр нэмэгдэх боломжтой.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөөлөл үзүүлнэ.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
4.Төрийн удирдлага, сайн	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.

засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, суртахуун ёс	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгож өгснөөр үйл ажиллагааны уялдаа холбоо сайжирч, хамтран ажиллах нөхцөлийг нэмэгдүүлнэ.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхой болгосноор төрийн захиргааны албан хаагчдын эрх үүрэгт тодорхой өөрчлөлт орж болно.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрхийг баталгаажуулахад эергээр нөлөөлнө.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-г нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.

	сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх			
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөлгүй.

#### 4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	

3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй.
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сэргээр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	
7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	

**ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАНУУДЫГ ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ**

	Зохицуулалтын хувилбарууд	Хувилбар 1.	Хувилбар 2.
		“Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулах замаар Хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох.”	“Хөрөнгө оруулалтын харилцаанд тулгамждаж буй асуудлыг захиргааны шийдвэр буюу захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар зохицуулах.”
Ша	Зорилгод хүрэх байдал	Тус хувилбарын хувьд:	Тус хувилбарын хувьд захиргааны хэм

		<p>- Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна" гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт "Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна" гэж заасан төрийн үүрэгтэй холбоотой;</p> <p>-Хөрөнгө оруулалт татахад, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хангах, хамгаалахтай холбоотой зохицуулалтууд нь Хөрөнгө оруулалтын тухай хуулиар баталгааждаг</p>	<p>хэмжээний акт буюу захиргааны шийдвэрээр тус хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад чиглэсэн асуудлыг цогцоор шийдвэрлэх боломжгүй тул уг зорилгод бүрэн нийцэхгүй байна.</p>
Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө		<p>Хөрөнгө оруулагчдын эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ. Гэхдээ хувилбар 2-оос тухайн хувилбар нь илүү эерэг үр нөлөөг үзүүлж байна. Тухайлбал, хөрөнгө оруулалтын орчныг боловсронгуй болгоход чиглэсэн зарчмын өөрчлөлтүүдийг шинэчилсэн найруулгын төсөлд тусгаснаар захиргааны хэм хэмжээний акт гаргах замаар шийдвэрлэх боломжгүй асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.</p>	<p>Хөрөнгө оруулагчдын эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд эерэг нөлөө үзүүлнэ.</p>
Зардал, үр өгөөжийн харьцаа		<p>Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг баталсанаар төрийн байгууллагуудад шинээр</p>	<p>Зардлын хувьд өмнөх хувилбартай ижил үр дагавартай хэдий ч өмнө дурдсанаар үр, өгөөж муутай байна.</p>

	зардал үүсгэхгүй ба үр өгөөжийн харьцааны хувьд үр өгөөж нь илүү байхаар байна.	
Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх	Хууль тогтоомжтой нийцэж байна. Тухайлбал, УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 4-т "Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрдээ хүрсэн, дундаж давхарга зонхилсон, ядуурал эрс буурсан, эдийн засгийн хөгжлийн бодлогын суурийг бүрдүүлж, дотоод хэрэгцээгээ өөрсдөө хангадаг, экспорт эрчимжсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бүрдүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай улс болно", уг зорилгыг хэрэгжүүлэх I үе шат (2021-2030)-нд "1.гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих нөхцөл бүрдсэн байна", "Хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлсэн байна", мөн "“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа"-ны 4.3.12-т "Гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зохицуулалтын орчныг сайжруулна" гэж тус тус тусгагдсан байна.	Тус хувилбарыг сонгосон тохиолдолд хууль тогтоомжтой нийцүүлэн захиргааны шийдвэр гаргах боломжтой.
Тухайн зохицуулалтаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдийг тогтоох	Хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй гадаад, дотоодийн хөрөнгөр оруулагч,	Хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй гадаад, дотоодийн хөрөнгөр оруулагч, гадаадын хөрөнгө

		гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж.	оруулалттай аж ахуйн нэгж.
--	--	---	----------------------------

Дээрх судалгаанд үндэслэн тухайн хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

#### **Гарч болох эерэг үр дүн**

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлт, зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд хувилбар 1 нь хувилбар 2-оос эерэг үр дүнг үзүүлж байгаа нь харагдаж байна. Тухайлбал, хувилбар 1-ийг сонгосон тохиолдолд зохицуулалтын агуулга, шаардлага, нийгэмд үзүүлэх нөлөөний хувьд илүү байна.

#### **Гарч болох сөрөг үр дагавар**

Гарч болох сөрөг үр дагаварын хувьд хувилбар 2 нь хувилбар 1-ээс сөрөг үр дагавар ихтэй болох нь дээрх хүснэгтээр тодорхойлогдож байна.

### **ЗУРГАА. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ**

Дээр дурдсанчлан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, улмаар эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийг сайжруулах, олон улсын тэргүүн туршлагаас судлах, олон улсын байгууллагуудын зөвлөмж, саналыг харгалзах, Хөрөнгө оруулалтын хуульд зарим шаардлагатай өөрчлөлтийг оруулах хэрэгцээ, шаардлага байгаа билээ. Тухайлбал дэлхийн бусад орны хөрөнгө оруулалтын орчинг эргэн авч үзэж, одоогийн тулгамдаж байгаа асуудлуудыг дэлхийн жишигтэй харьцуулж хэрхэн шийдвэрлэсэн сайн туршлагаас суралцах шаардлагатай байна.

Энэхүү харьцуулсан судалгаанд Азийн хөгжиж буй орнуудын төлөөлөл болгон Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Вьетнам Улс, хуучин социалист системийн орнуудаас төлөөлүүлэн Бүгд Найрамдах Чех Улс болон Зүүн хойд Азийн бүсэд байрлах байршил, газар байршилтай Бүгд Найрамдах Казахстан Улс, уул уурхай олборлох салбарт түшиглэн хөрөнгө оруулалтыг татах сайн жишээ болсон Бүгд Найрамдах Чили Улсын хөрөнгө оруулалтын бодлого, хууль тогтоомжийн талаар орууллаа.

БНСУ, БНВУ, БНЧУ, БНКУ болон Чили улсуудын хөрөнгө оруулалтын орчин, хууль эрх зүй батлагдсан хугацаанаас хойш тогтвортой хэрэгжиж байна.

#### **Төрийн эрх бүхий байгууллага.**

Дээрх бүх улсад хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бизнесийг хөхиүлэн дэмжих бие даасан агентлаг байгуулагдаж, бүтцийн хувьд өөрчлөлтгүй, тогтвортой үйл ажиллагаа явуулах нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх оновчтой хэлбэрт тооцогдож байна. Агентлагууд нь шаардлагатай нөхцөлд өөрийн хэрэгжилт, практик туршлага, төр болон хөрөнгө оруулагчдад тулгамдаж байгаа хүндрэл бэрхшээлд үндэслэн хууль тогтоомжийн болон холбогдох дүрэм, журам зэрэг зохицуулалтад өөрч өөрчлөлт оруулах санал зөвлөмжийг боловсруулах нийтлэг эрх ба үүрэгтэй.

Хөрөнгө оруулагчдыг дэмжих чиг үүрэгтэй агентлагаас гадна Чили улсад тус улсын Ерөнхийлөгчид стратегийн бодлогын зөвлөгөө өгөх сайд нарын зөвлөл хөрөнгө оруулалтын асуудлын давхар хариуцан ажилладаг. Мөн БНСУ-ын Худалдаа, хөрөнгө оруулалт хариуцсан дэд сайд, газрын дарга нар хөрөнгө оруулагч гадаадын компаниудын удирдлагууд, Худалдаа, аж үйлдвэрийн танхимын гишүүд, худалдаа, эдийн засгийн асуудал эрхэлсэн ажилтнуудтай тогтмол уулзаж, санал солилцдог байна.

#### Бодлогын дэмжлэг.

БНСУ, БНВУ, БНЧУ, БНКУ болон Чили улсын Засгийн газраас гадаадын хөрөнгө оруулалтыг эх орондоо татах чиглэлээр дараах байр суурьтай байдаг. Үүнд:

- Хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгах;
- Нэг цэгт иж бүрэн шийдлийн системийг бүрдүүлэх;
- Зөвшөөрөл олгох процесс, дамжлагыг хялбаршуулах, автоматжуулан хүнээс хамаарлыг бууруулах;
- Хөрөнгө оруулагчдаас төслийн хэрэгжилт дээр нь шаарддаг олон тооны шаардлагуудыг бууруулах;
- Хөрөнгө оруулагч газар болон үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эзэмших, бизнесийн зорилгоор ашиглах бололцоо олгох;
- Өөрийн хөрөнгийг чөлөөтэй ашиглах, гадаад улс руу шилжүүлэх;
- Төрөөс хувийн өмчийн хөрөнгө, орлогыг хураан авахыг хязгаарлан зөвхөн нийтийн зайлшгүй хэрэгцээг харгалзах;
- Хөрөнгө оруулалтын урамшууллыг хоёр чиглэлээр нэмэгдүүлэх, хүрээг нь тэлэх. Үүнд: стратегийн хөрөнгө оруулагч болон энгийн төсөл хэрэгжүүлэхэд ялгамжтай хандаж, тус тусад нь өөр төрлийн хөрөнгө оруулалтын дэмжлэг үзүүлэх;
- Эдийн засгийн өсөлт бий болгох, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажлын байрыг олноор бий болгох салбар болон ногоон төсөл, хөтөлбөр, төв суурин газар бус орон нутагт хөрөнгө оруулалт хийхийг түлхүү дэмжих;
- Хөрөнгө оруулалт татах эрх зүйн орчныг ээлтэй болгох, нээлттэй хэлбэрээр зах зээлээс хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлэх;
- Холбогдох дүрэм, журмын тоог цөөрүүлэх;

#### Стратегийн салбар

Улс бүр стратегийн 5 хүртэлх салбарыг хуульдаа нэрлэж дурдсан, тэдгээр салбарт хийгдэх хөрөнгө оруулалтад төр бодлогын дэмжлэг үзүүлэх чиглэлтэй ба харин үйл ажиллагаа явуулах компаниуд хууль хэрэгжүүлсэн, зөрчил гаргаагүй, төлөвлөгөө эсхүл гэрээний хэрэгжилтийг хангасан нөхцөлд төрөөс эдэлж болох хөнгөлөлт, чөлөөлөлт, татварын болон татварын бус дэмжлэгийг хүртэх нөхцөлтэй байна.

### Салбарын хязгаарлалт

Зарим салбарт дотоодын хөрөнгө оруулагч хөрөнгө оруулахад нээлттэй боловч гадаадын хөрөнгө оруулагчид хязгаарлалт тавьсан. Үүнд Казахстан банк, даатгалын салбарт гадаадын хөрөнгийн оролцоог хязгаарлах, банк болон гадаадын даатгалын компанийн салбарууд үйл ажиллагаа явуулахыг хориглодог ба хөдөө аж ахуйн газрыг гадаадын хуулийн этгээд, хувь хүн эзэмшихийг хязгаарладаг.

Харин Чили, Чех улсад гадаадын хөрөнгө оруулалтыг хориглосон, хязгаарласан салбар байхгүй. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч, дотоодын хөрөнгө оруулагч гэх ялгамж хуульд заагаагүй байна.

### Хөрөнгө оруулалтын босго

Гадаадын хөрөнгө оруулагчдад тавих босго хөрөнгө оруулалтын хэмжээ заасан улс ганцхан БНСУ байна. 1981 онд гадаадын хөрөнгө оруулалтын босго хэмжээг 500,000 воноос 100,000 вон болгож бууруулсан. Хуульд "Хөрөнгө оруулалтын хэмжээ гэдэг нь хувьцааг худалдаж авсан үнийн дүн бөгөөд хоёр болоод түүнээс дээш гадаадын иргэд хамтарсан хөрөнгө оруулалт хийвэл тус тусдаа төлөх хэмжээг (100 сая вон) хэлнэ. Хэрвээ хувьцааны үнэ нь хөрөнгийн хорогдлоос болж унасан ч гадаадын хөрөнгө оруулалттай компанид ямар нэгэн буцаан олголт хийгдээгүй бол хувьцаа авах үед хийсэн хөрөнгө оруулалтын хэмжээг өөрчлөгдөөгүй гэж үзнэ" гэж заажээ. Мөн хөрөнгө оруулалтын босго тогтоож өгөхдөө хөрөнгө оруулалтын олон төрлийн урамшуулал ба дэмжлэгийг үзүүлж байгаа нь Монгол Улсад хэрэгжүүлж буй Хөрөнгө оруулалтын гэрээ, Тогтворжуулах гэрчилгээ олгох нөхцөлтэй ижил түвшинд байна. Хөрөнгө оруулалтын босго нь үндэсний үйлдвэрлэлийг түлхүү дэмжих, гадаадын хөрөнгө оруулалтыг аль болох дотоодын хөрөнгө оруулагчтай хамтрах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлтэй, босго дүнгээс хамаарч урамшууллыг нэмэгдүүлдэг нөхцөлтэй байна. Хөрөнгө оруулалтын босгыг зөвхөн дээрх нөхцөлд тогтоож өгсөн нь бусад нөхцөлд хөрөнгө оруулалтыг хязгаарлах нөхцөлөөс сэргийлсэн байна.

Харин бусад улсад гадаадын хөрөнгө оруулагч хуулийн этгээд байгуулах, хөрөнгө оруулалт хийхэд босго хэмжээ заагаагүй байна. БНСУ-ын энэхүү бодлого нь дотоодын аж ахуйн нэгжийг дэмжих, дотоодын үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийн гарц, нэмүү өртөг, ажлын байр бий болгох зэргийг нэмэгдүүлэх 1981 оноос өмнөх стратегитай шууд холбоотой бөгөөд энэ хугацаанаас өмнө тус улс "Чеболь" буюу үндэсний томоохон корпорацуудаас хамааралтай эдийн засагтай болсон нь стратегийн зорилго, зорилтоор гадаад, дотоодын аль хөрөнгө оруулалтыг түлхүү

дэмжихээр тодорхойлсон урт хугацааны бодлого, үйл ажиллагааны чиглэлтэй хамааралтай.

Чили, БНВУ, БНЧУ, БНКУ улсад гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгж байгуулахад хөрөнгө оруулалтын хэмжээнд заасан дээд, доод босго тавьсан зохицуулалт байхгүй.

#### Татварын болон бусад дэмжлэг

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын урамшууллыг голдуу татварын хөнгөлөлт хэлбэрээр, бизнесийн үйл ажиллагааг явуулж эхлэхэд олгож байна. Үүнд, компанийн татвар, орлогын татвар, орон нутгийн татвар/үл хөдлөх хөрөнгийн татвар/ зэргийг хөнгөлдөг байна. Мөн бараа бүтээгдэхүүнийг гаалийн хураамж, нэмүү өртгийн татвараас чөлөөлдөг байна.

Хэрэв гадаадын хөрөнгө оруулалт тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд, төв засгийн газар болон орон нутгийн засаг захиргаанаас мөнгөн дэмжлэг үзүүлэх боломж байдаг. Тухайлбал, газар худалдан авах өртөг, түрээсийн төлбөр, ажилтны сургалт, боловсролд зарцуулсан төлбөрт татаас өгөх зэрэг болно.

Дээрх улс орнууд хөнгөлөлт чөлөөлөлтийг эдлүүлэхдээ салбар тус бүр өөр өөр байх ба ихэвчлэн эхний 3 жил татвараас чөлөөлөх, жижиг хот болон алслагдсан дүүрэгт хийгдсэн хөрөнгө оруулалтыг хөнгөлөлт чөлөөлөлт түлхүү хамруулахаар заасан нь нийтлэг байна.

Жижиг хотод бий болгосон барилга, худалдан авсан тоног төхөөрөмж, үл хөдлөх хөрөнгийн нийт өртгийн 20-25 хүртэлх хувийг төрөөс татаас хэлбэрээр олгож болохоор БНСУ-ын хуульд заасан бол Чех улсад Засгийн газраас баталсан салбарт үйлдвэрлэл явуулах, 500,000,000 короны зардалтай, түүнээс 250,000,000 короныг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан, 500 шинэ ажлын байр бий болгосон төсөлд, технологийн салбарт 200,000,000 короны үйл ажиллагааны зардалтай, түүнээс 100,000,000 короныг тоног төхөөрөмж худалдан авахад зарцуулсан, 100 ажлын байр шинээр бий болгох төсөлд, бусад төсөлд урамшуулалт, хөнгөлөлт, чөлөөлөлт хүртэхэд 20 ба түүнээс дээш ажлын байр бий болгосон байх, 3.6-4 сая еврогийн хөрөнгө оруулалт хийсэн бол эхний 10 хүртэлх жилд аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас чөлөөлөх, бэлэн мөнгөний урамшуулал олгож болохоор заасан ба төрөөс авч болох нийт урамшууллын хэмжээг 45.75 сая крон хүртэл буюу нийт зардлын 19 хувь хүртэл байж болохоор заажээ.

БНКУ улсын Засгийн газар уул уурхай, төмөр замын тоног төхөөрөмж, цахилгаан тоног төхөөрөмж, химийн бүтээгдэхүүн, барилга, төмөрлөгийн үйлдвэрлэл, хүнсний үйлдвэрлэлийн сав баглаа боодол, эм, мэдээлэл, харилцаа холбоо, цахилгаан эрчим хүч, салхины болон нарны эрчим хүчний салбарт хөрөнгө оруулалтыг дэмжих тусгай урамшуулалтай. 2009 онд орлогын албан татварыг 30 хувиас 20 хувь, нэмүү өртгийн албан татварыг 16 хувиас 12 хувь болгож тус тус бууруулсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөлд буюу төрийн байгууллагаас баталсан тэргүүлэгч салбарт оруулах хөрөнгө оруулалтын 2 сая мөнгөн тэмдэгттэй тэнцэх хэмжээний үйл ажиллагааны зардалтай шинэ, хуучин төсөлд гаргасан хүсэлтийн дагуу мөн тэргүүлэгч хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын хөнгөлөлт, чөлөөлөлтийг олгохоор байна.

Хөрөнгө оруулагчаас зөвхөн батлагдсан төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтыг хийх шаардлага тавьсан ба гадаад, дотоодын хөрөнгө оруулалт гэх ялгамж хуульд байхгүй.

#### Хуулийн хэрэгжилтийг хянах

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах асуудлыг дээрх бүх улс үйл ажиллагаа явуулах эрх, зөвшөөрөл, газрын эрхийг олгох, сунгах болон үзүүлж байгаа татвар болон татварын бус дэмжлэгтэй шууд уялдуулсан. Ялангуяа үйлдвэрлэл, аялал жуулчлал, хөдөө аж ахуйн салбарт ногоон төсөл, инновац, шинэ технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжихдээ хөнгөлөлт, урамшуулал, визний нөхцөл, газар болон үл хөдлөх хөрөнгийн эрх олгох, сунгахтай уялдуулсан.

Жишээ нь дараах тохиолдолд дэмжлэгийг цуцлах, эрхийг олгохгүй эсхүл сунгахгүй байхаар заажээ. Тэдгээрт:

- Ногоон төслийн концепци алдагдсан;
- Ажлын байр бий болгоогүй;
- Ил тод байдлыг хангаагүй, компанийн цаад эцсийн эзэмшигчдийн харьяалал тодорхойгүй;
- Тухайн улсын хууль тогтоомж, дүрэм журам болон олон улсын нийтлэг стандартыг хэрэгжүүлээгүй, зөрчсөн;
- Тайлан, мэдээллийг хугацаандаа хүргүүлээгүй зэрэг багтаж байна.

#### **Дүгнэлт**

Дээрх харьцуулсан судалгаанд хамрагдсан улсуудад хөрөнгө оруулагчид дэмжлэг үзүүлэх, бизнесийг хөхиүлэн дэмжих байгууллагуудын бүтэц, чиг үүргийг хууль тогтоомждоо оновчтой тодорхойлж, тогтвортой үйл ажиллагаа явуулах нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх оновчтой хэлбэр гэж үздэг байна. Хөрөнгө оруулалтын хэмжээнд босго тогтоох зохицуулалтын тухайд судалгаанд хамрагдсан улсуудаас зөвхөн БНСУ-д л байх ба бусад орнуудад хөрөнгө оруулалтын босго тогтоосон зохицуулалт байдаггүй байна. Түүнчлэн Хууль эрх зүйн орчныг тогтвортой байлгах, үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрөл олгох процесс, шат дамжлагыг хялбаршуулах, төрийн зүгээс шаарддаг олон тооны шаардлагуудыг бууруулах, өөрийн хөрөнгийг чөлөөтэй ашиглах, гадаад улс руу шилжүүлэх боломжоор хангах, хөрөнгө оруулалт татах эрх зүйн орчныг ээлтэй болгох, нээлттэй хэлбэрээр зах зээлээс хөрөнгө оруулалт татах нөхцөлийг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журмын тоог цөөрүүлэх бодлогыг баримталж ажилладаг байна. Мөн хөрөнгө оруулагчдад үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэгийг тухайн хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаандаа хөрөнгө оруулалтын болон бусад салбарын хууль

тогтоомжийг хэрхэн дагаж мөрдөж, хэрэгжүүлж байгаа нөхцөл байдалтай нь уялдуулжээ.

## **ДОЛОО. ЗӨВЛӨМЖ**

Тус судалгаа буюу “Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа”-ны хүрээнд 6 бүлэг бүхий аргачлалыг үндэслэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээ, шаардлагыг тандан судаллаа. Энэхүү үе шатуудыг дүгнэн үзвэл дараах үр дүнд хүрч байна.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах хэрэгцээ шаардлага нь хөрөнгө оруулалтын талаар эрх зүйн орчин тогтворгүй, зарим тохиолдолд тодорхойгүй бөгөөд ойлгомжгүй, гадаадын хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах механизм бодитой бүрдээгүй, хөрөнгө оруулалттай холбоотой асуудалд үл ялгаварлах зарчмыг хуульд тусгагдаагүй байдлаас, мөн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгохоор шийдвэрлэсэн бол хөрөнгө оруулалтаа хийж буй эсэхэд хяналт тавих, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа хэвийн явуулахад зөвлөмж, чиглэл өгөх талаар зохицуулалт дутмаг, хөрөнгө оруулалтын харилцаанд оролцож буй төрийн байгууллагуудын чиг үүрэг тодорхойгүй, хуульд бүрэн тусгагдаагүй, зааг ялгааг хангалттай тогтоож өгөөгүй байгаагаас үүдэлтэй байна.

Судалгааны хүрээнд дээр дурдсан хэрэгцээ шаардлагад үндэслэн хувилбар буюу зохицуулах аргуудад дүгнэлт хийн тэднээс хоёр хувилбарыг сонгож хооронд нь харьцуулсан. Тус харьцуулалтын үр дүнд хувилбар 1 буюу Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчлэн боловсруулж батлах хувилбар нь зорилгод хүрэх байдал, зардал, өгөөжийн хувьд илүү болох нь ажиглагдсан.

Иймд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж хөрөнгө оруулагчийн хууль ёсны баталгааг хангах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулахтай холбоотой дараах зохицуулалтыг шинээр тусгах нь зүйтэй байна.

-Хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл гомдол гаргах эрхийг баталгаажуулж, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт оруулж олон улсын сайн туршлагыг хуульд тусгах;

-Хөрөнгө оруулагчийн хөрөнгийг хууль бусаар хураан авахгүй байх, хууль ёсоор хураан авахын тулд нийтийн эрх ашгийн төлөө, хуульд заасан үндэслэлээр, үл ялгаварлах зарчимд нийцүүлж хураан авах нөхцөлийг хуульчлах, улмаар хураан авахтай холбоотой нөхөн төлбөрийн асуудлыг хуульчлан тусгах;

- Хөрөнгө оруулалт татах бодлогын хүрээнд гадаадын хөрөнгө оруулагч нарт үзүүлдэг хязгаарлалтын бодлогыг өөрчилж хөрөнгө оруулалтын үндэсний нөхцөл

буюу дотоодын хөрөнгө оруулагч нартай ижил нөхцөлөөр эрх ашгаа хамгаалуулах асуудлыг хуульчлах;

- Мөн тодорхой салбар дахь гадаадын төрийн өмчит компанийн хөрөнгө оруулалтыг хязгаарлах зөвшөөрлийн процессыг алга болгох;

-Хөрөнгө оруулалтын маргааныг арбитрын харьяаллаар шийдвэрлүүлэх;

-Хуулийн төсөлд шинээр хөрөнгө оруулалтын талаарх Засгийн газар, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Дипломат төлөөлөгчийн газрын эрх үүргийг тусган төрийн байгууллагын хоорондын нэгдсэн уялдааг хангах нөхцөлийг бүрдүүлэх;

-Одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгохоор тусгагдсан бол хуулийн төсөлд хөрөнгө оруулалтаа хийж буй эсэхэд хяналт тавих зохицуулалтыг тусгаж, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа хэвийн явуулахад зөвлөмж, чиглэл өгөх зохицуулалтыг нарийвчлан тусгах;

-Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулахаар сонирхож буй аж ахуйн нэгжүүдэд зориулсан хөрөнгө оруулалтын орчин, хууль, эрх зүйн сурталчилгаа, мэдээллийг нэг цонхоор хүргэх, хөрөнгө оруулалт татах төслүүдийг бэлтгэх, бэхжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчлан тусгаж, хөрөнгө оруулагчдад зөвлөх, дэмжих болон бусад холбогдох үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

-Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэр томъёоны тодорхойлолтыг оновчтой, ойлгомжтой болгож, хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг, нарийвчлан зохицуулалт хийх шаардлагатай хэм хэмжээний актын батлах эрхийг тодорхойлох.



**ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ**

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**2023 он**

## **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫНТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

### **Нэг.Ерөнхий зүйл**

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.2-т “эдийн засгийн аюулгүй байдал”-ын хүрээнд олон тулгуурт, оновчтой бүтэц бүхий, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, эдийн засгийн өөрийгөө тэтгэх чадавхийг бүрдүүлж, эдийн засгийн бие даасан байдал, хэвийн үйл ажиллагааг хангах, үндэсний орлогыг бүрдүүлэх бодлого баримтлах”-аар заасан бөгөөд 3.2.2-т “хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлогын хүрээнд үндэсний хөрөнгө оруулагчдын эдийн засаг дахь хувь, оролцоог нэмэгдүүлэх, хамгаалах бодлого хэрэгжүүлж, бизнесээ өргөжүүлэх, олон улсын түвшинд өрсөлдөх чадвараа дээшлүүлэх, улмаар улс орны эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх”-ээр заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.1.21-д “Төсөв, мөнгө, зээл, гадаад худалдаа, хөрөнгө оруулалтын харилцан уялдаатай бодлого хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлт болон бүтцийн өөрчлөлтийн ололтыг цаашид тогтвортой хадгална.” гэж заасан.

Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 5.2.3-т “гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ” гэж заасан.

Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын эдийн засагт үзүүлж байгаа сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийн суурийг тэлэх, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх, төрийн бүтээмжийг сайжруулах зорилгоор Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг төр, хувийн хэвшлийн түншлэл болон хөрөнгө оруулалтын түншлэлд тулгуурлан хэрэгжүүлэхээр тусгагдсан.

Хөрөнгө оруулалт татахад бодлого, эрх зүйн орчноо хөрөнгө оруулагчдад сурталчилан таниулах, зорилтот улс, бус нутаг, эдийн засгийн салбар, тэргүүлэх чиглэлээр нь хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл, арга хэмжээг санал болгох, сурталчлах, хөрөнгө оруулалт татах бизнес уулзалт, форум, арга хэмжээг зохион байгуулах ажлыг эрчимтэй зохион байгуулах, цаашлаад хөрөнгө оруулагчид Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаагаа эхлүүлэхэд нь шаардлагатай төрийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, мэдээллээр хангах, хууль тогтоомжид

заасан дэмжлэг, урамшууллыг бодитоор үзүүлэх, эрх ашгийг хамгаалах, баталгаагаар хангагдах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Үүний тулд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн зохицуулалт, түүний хэрэгжилт тогтвортой, бодитой бөгөөд үр дүнтэй, хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулах сонирхлыг татахуйц байх шаардлагатай.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, хөрөнгө оруулагчид үйлчилгээ үзүүлэх чиг үүргийг хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага буюу Эдийн засаг, хөгжлийн яам дангаараа хэрэгжүүлэхээр заасан нь хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилго, зорилтыг үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Түүнчлэн хөрөнгө оруулагч нарын хувьд хамгийн их тулгамддаг асуудал нь төрийн үйлчилгээг хүнд сурталгүй авах, улмаар төрийн байгууллагын буруутай үйлдлээс эрх ашиг нь хөндөгдсөн тохиолдолд эрх бүхий байгууллагад гомдол гаргах механизмыг хялбаршуулах, улмаар оруулсан хөрөнгө оруулалтаа хамгаалуулах, хууль ёсоор хураан авсан тохиолдолд нөхөн төлбөрийг үл маргах журмаар авдаг байх, зөрчигдсэн эрх ашгаа хамгаалуулахаар арбитра хандах нөхцөл журмыг маш тодорхой хуульчлах шаардлагатай байгааг үндэслэн хөрөнгө оруулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулсан байна. Тус хуулийн төсөл нь нийт 34 зүйлтэй.

#### **Хоёр.Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгосон байдал, үндэслэл**

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусгагсан үндсэн асуудлыг зохицуулахаар зорьсон чиглэл тус бүрээс хуулийн төслийн зорилтыг хамгийн сайн илэрхийлж чадах зохицуулалтыг сонгож, хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай холбогдуулан, аргачлалд дурдсан "зорилгод хүрэх байдал", "ойлгомжтой байдал", "зардал", "харилцан уялдаа", гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээ хийхээр сонгож авсан.

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг хүснэлт 1-т үзүүлсний дагуу тогтоосон.

*Хүснэлт 1. Шалгуур үзүүлэлт*

<b>№</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>	<b>Тохирох шалгах хэрэгсэл</b>
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн

			зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
3	Зардал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хуулийн төслийн нөлөөллөөс иргэн аж ахуйн нэгж байгууллага, төрийн байгууллагад гарах нэмэгдэл зардлыг үнэлж тооцох.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

## **Гурав. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоосон байдал**

### **3.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал**

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Тус хуулийн төслийн үзэл баримтлалаар дараах зорилтыг дэвшүүлсэн байна.

1.Хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсэн гэж үзвэл гомдол гаргах эрхийг баталгаажуулж, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх талаар тодорхой зохицуулалт оруулж олон улсын сайн туршлагыг нэвтрүүлнэ;

2.Хуулийн төсөлд шинээр хөрөнгө оруулалтын талаарх Засгийн газар, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Дипломат төлөөлөгчийн газрын эрх үүргийг тусган төрийн байгууллагын хоорондын нэгдсэн уялдааг хангах нөхцөлийг бүрдүүлнэ;

3.Одоогийн Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах, тогтворжуулах гэрчилгээ олгохоор тусгагдсан бол хуулийн төсөлд

хөрөнгө оруулалтаа хийж буй эсэхэд хяналт тавих зохицуулалтыг тусгаж, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа хэвийн явуулахад зөвлөмж, чиглэл өгөх зохицуулалтыг тусгана;

4.Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулахаар сонирхож буй аж ахуйн нэгжүүдэд зориулсан хөрөнгө оруулалтын орчин, хууль, эрх зүйн сурталчилгаа, мэдээллийг нэг цонхоор хүргэх, хөрөнгө оруулалт татах төслүүдийг бэлтгэх, бэхжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчлан тусгаж, хөрөнгө оруулагчдад зөвлөх, дэмжих болон бусад холбогдох үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

5.Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэр томъёоны тодорхойлолтыг оновчтой, ойлгомжтой болгож, хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг, нарийвчлан зохицуулалт хийх шаардлагатай хэм хэмжээний актын батлах эрхийг тодорхойлж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлнэ;

6.Хөрөнгө оруулагчдыг дэмжих, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгана.

Иймд үзэл баримтлалын төсөлд тусгасан эдгээр зорилтод Хуулийн төсөл нийцэж байгаа эсэхийг үнэлэв.

Хуулийн төслийн үзэл баримтлал	Хуулийн төслийн зохицуулалт
<p>Хөрөнгө оруулалтын хамгаалалтын тогтолцоог бүрдүүлэх, хөрөнгө оруулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хууль ёсны ашиг, сонирхол нь зөрчигдсөн гэж үзвэл гомдол гаргах эрхийг баталгаажуулж, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх талаар зохицуулалтыг бий болгох тухайд</p>	<p>Хуулийн төслийн 6 дугаар бүлэгт төрийн байгууллага, албан тушаалтны үйлдэл, эс үйлдэхүйн улмаас эрх, ашиг сонирхол нь хөндөгдсөн тухай гомдлыг Хөрөнгө оруулалтын төрийн захиргааны төв байгууллагад гаргаж, уг гомдлыг хянан магадлах, шийдвэрлэх талаар процесс ажиллагааг нарийвчлан тусгаж өгсөн байна.</p> <p>Мөн хуулийн төслийн 7 дугаар бүлэгт хөрөнгө оруулагч болон Монгол Улсын төрийн байгууллага хооронд үүссэн хөрөнгө оруулалттай холбоотой маргааныг шийдвэрлэх арга замыг тусгаж өгсөн байна. Тухайлбал, хуулийн төсөлд талууд хөрөнгө оруулалтын маргааныг 6 сарын дотор хэлэлцээний замаар шийдвэрлэх, уг хугацаанд шийдвэрлэж чадаагүй тохиолдолд арбитраар шийдвэрлүүлэх талаар тусгажээ.</p> <p>Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан 1 дүгээр зорилтыг хангаж байна.</p>

<p>Хуулийн төсөлд шинээр хөрөнгө оруулалтын талаарх Засгийн газар, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, төрийн бусад байгууллага, нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Дипломат төлөөлөгчийн газрын эрх үүргийг тусган төрийн байгууллагын хоорондын нэгдсэн уялдааг хангах нөхцөлийг бүрдүүлэх тухайд</p>	<p>Хуулийн төслийн 3 дугаар бүлэгт Хөрөнгө оруулалтын талаарх төрийн байгууллагуудын чиг үүрэг, бүрэн эрхийг тогтоож өгсөн байна. Тухайлбал, Засгийн газар, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, дипломат төлөөлөгчийн газар болон тус харилцаанд оролцогч төрийн бусад байгууллагын чиг үүрэг бүрэн эрх тусгагджээ.</p> <p>Дээрх байдлаар төрийн байгууллагуудын чиг үүрэг, бүрэн эрхийг хуулийн төсөлд тусгахдаа давхардал, хийдэл үүсгээгүй байна.</p> <p>Харьцуулахад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуульд зөвхөн хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрх, үүрэг тусгагдсан байна.</p> <p>Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан хоёрдугаар зорилтыг хангаж байна.</p>
<p>Хөрөнгө оруулалтаа хийж буй эсэхэд хяналт тавих зохицуулалтыг тусгаж, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа хэвийн явуулахад зөвлөмж, чиглэл өгөх зохицуулалтыг тусгах</p>	<p>Хуулийн төслийн 25 дугаар зүйлд Хөрөнгө оруулалтын гэрээ, тогтворжуулах гэрчилгээний хэрэгжилтэд хяналт тавих талаар зохицуулалтыг тусгасан байна.</p> <p>Тус зохицуултад тусгаснаар хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан болон тогтворжуулах гэрчилгээ авсан этгээдийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, хяналт тавьж ажиллах чиг үүргийн Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлэхээр байна.</p> <p>Түүнчлэн дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд баримтлах журмыг Хөрөнгө</p>

	<p>оруулалтын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батлахаар төсөлд тусгагджээ.</p> <p>Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан гуравдугаар зорилтыг хангаж байна.</p>
<p>Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулахаар сонирхож буй аж ахуйн нэгжүүдэд зориулсан хөрөнгө оруулалтын орчин, хууль, эрх зүйн сурталчилгаа, мэдээллийг нэг цонхоор хүргэх, хөрөнгө оруулалт татах төслүүдийг бэлтгэх, бэхжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчлан тусгаж, хөрөнгө оруулагчдад зөвлөх, дэмжих болон бусад холбогдох үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх</p>	<p>Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг тусгагдсан.</p> <p>Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийн хуулийн төсөлд дараах байдлаар тусгажээ.</p> <ul style="list-style-type: none"> <li>-хөрөнгө оруулалтыг хадгалах, өргөжүүлэх зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;</li> <li>-хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах;</li> <li>-хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, өргөтгөх, хадгалахад мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар дэмжлэг үзүүлэх;</li> <li>-хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;</li> <li>-хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх;</li> <li>-хөрөнгө оруулалт татах, болон авахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, сонирхогч этгээдийг мэдээллээр хангах.</li> <li>-хөрөнгө оруулалтын орчны чиглэлээр төв банк, төсөв, санхүү, хөдөлмөр эрхлэлт,</li> </ul>

	<p>татвар, гааль, нийгмийн даатгал, бүртгэл, гадаадын иргэн, харьяат, газар, чөлөөт бүс болон шүүхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас хөрөнгө оруулалттай холбоотой статистик мэдээллийг улирал, хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгдсэн статистик мэдээллийг гаргах.</p> <p>Хуулийн төсөлд тусгагдсан дээрх чиг үүргийг харвал үзэл баримтлалд тусгагдсан "Хөрөнгө оруулагч болон хөрөнгө оруулахаар сонирхож буй аж ахуйн нэгжүүдэд зориулсан хөрөнгө оруулалтын орчин, хууль, эрх зүйн сурталчилгаа, мэдээллийг нэг цонхоор хүргэх, хөрөнгө оруулалт татах төслүүдийг бэлтгэх, бэхжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нарийвчлан тусгах, хөрөнгө оруулагчдад зөвлөх, дэмжих болон бусад холбогдох үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх" зорилтыг хангаж байна.</p>
<p>Хөрөнгө оруулалтын тухай хуульд нэр томъёоны тодорхойлолтыг оновчтой, ойлгомжтой болгож, хөрөнгө оруулалтын баталгаа, хөрөнгө оруулалтын хэлбэр, хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг, нарийвчлан зохицуулалт хийх шаардлагатай хэм хэмжээний актын батлах эрхийг тодорхойлж, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх</p>	<p>Хуулийн төслийг 4 дүгээр зүйлд хуульд хэрэглэгдэх нэр томъёог дахин нарийвчлан тодорхойлсон байна. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн тодорхойлолтын тодорхой болгож, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 100 мянган америк.доллар хөрөнгө оруулалтын хэмжээний босгыг хасахаар тусгасан байна.</p> <p>Мөн хуулийн төслийн 5, 6, 7, 8 дугаар зүйлүүдэд Монгол Улсад хөрөнгө оруулах хэлбэр, Хөрөнгө оруулагчийн хувьд эдлэх баталгаа, хөрөнгө оруулагчийн эрх, үүргийн талаар зохицуулалтуудыг тусгажээ.</p> <p>Дээрх зохицуулалтаар хөрөнгө оруулах хэлбэрийг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулиас илүү олон хэлбэрээр тодорхойлж, тусгасан байх ба хөрөнгө оруулалтад тооцогдохгүй зүйлсийн жагсаалтыг мөн гаргаснаараа илүү ойлгомжтой нөхцөл байдлыг бий болгохоор байна.</p>

	Иймд тус хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан тавдугаар зорилтыг хангаж байна.
Хөрөнгө оруулагчдыг дэмжих, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгах	Хуулийн төслийн 4 дүгээр бүлэг Хөрөнгө оруулалтын дэмжлэгийн талаар зохицуулсан ба дэмжлэг нь татварын болон татварын бус дэмжлэгийн төрлөөс бүрдэж байна. Түүнчлэн хуулийн төслийг бүхэлд нь авч үзвэл хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн үргэлжлүүлэх зорилтыг хангахад тус хуулийн зорилго чиглэсэн байна.

### 3.2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн боловсруулалт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28, 29, 30, 32 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгасан.

Хуулийн төсөл нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томъёологдсон эсэхийг тогтоох зорилгоор иргэд, олон нийтээс хуулийн төслийн ойлгомжтой байдал гэсэн шалгах хэрэгслийн хүрээнд ойлгомжгүй байгаа зохицуулалт байхгүй талаар саналаа ирүүлсэн.

<b>Хууль тогтоомжийн тухай хууль 29 дүгээр зүйл. Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага</b>	
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд	Уг шаардлагыг хангасан

эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	
29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Уг шаардлагыг хангасан
29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Уг шаардлагыг хангасан
29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Уг шаардлагыг хангасан
29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Уг шаардлагыг хангасан.
<b>30 дугаар зүйл. Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага</b>	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Уг шаардлагыг хангасан
30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Уг шаардлагыг хангасан
30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Уг шаардлагыг хангасан
30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Уг шаардлагыг хангасан

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24, 28 дугаар зүйлд

### 3.3. “Зардал” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

Төрд үүсэх зардал: Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд Эдийн засаг, хөгжлийн сайдын төсвийн хүрээнд Хөрөнгө оруулалт, худалдааны газрын төсвийг 819.1 сая төгрөг байхаар баталсан тул төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй

Иргэнд үүсэх зардал: Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь иргэдэд нэмэлт зардал үүсгэхгүй.

Иргэн, аж ахуйн нэгжид: Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар аж ахуйн нэгжид нэмэлт зардал үүсгэхгүй.

#### 3.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтээр үнэлсэн байдал

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан асуудлыг тодорхойлох байдлаар хуулийн төслийг бүхэлд нь авч үзсэн.

Хүснэлт 4. Хуулийн төслийн аргачлалын дагуу үнэлсэн байдал

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Хуулийн төсөл нь Хөрөнгө оруулалтын тухай хуулийн зорилтод туссан хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын талаар төрийн байгууллагын эрх хэмжээг тодорхойлох болон хөрөнгө оруулалттай холбоотой бусад харилцааг зохицуулалтыг сайжруулах тул тухайн хуулийн зорилттой нийцэж байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх;	Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл тул хамаарна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Хуулийн нэр томъёоны тодорхойлолтыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын стандарт болон бусад хуульд нийцүүлсэн байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцсэн байна.
Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Нийцсэн байна.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх;	Хуулийн төслөөр хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан байна.
Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан байна.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан, нэг чиг үүргийг хоёр өөр төрийн байгууллага гүйцэтгэх, давхардуулсан зохицуулалт байхгүй байна.
Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг тусгасан.

холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааг нээлттэй сонгох боломжтой байхаар төсөлд тусгажээ.
Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн хувьд үндэсний нөхцөл үйлчлэхээр тусгажээ.
Хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй.
Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Тийм зохицуулалт тусгагдаагүй. Авлига, хүнд суртлыг таслан зогсоох буюу түүнийг шийдвэрлэхтэй холбоотой механизмыг тусгасан.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Хууль бус үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хөрөнгө оруулагчийг хохироор, төрийг хариуцлагад оруулсан албан хаагч, хувь хүнд албан тушаалын болон эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Дээрх судалгаанаас үзэхэд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь хууль тогтоомжтой уялдсан бөгөөд давхардалгүй банья.

### **Дөрөв. Үр дүнг үнэлж, зөвлөмж өгсөн байдал**

Дүгнэлт: Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал"-ын дагуу үнэлэхэд хуулийн төсөл нь хуулийн төслөөр тавьсан зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байдлаар боловсруулагдсан байна.

- Хуулийн төслийн зорилт нь үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлага, үндэслэлийг бүрэн илэрхийлж чадсан байна.

- Хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төсөлд тодорхойлсон зорилго, зорилтыг бүрэн илэрхийлсэн байна.

- Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хуулийн төсөлд тавигдах шаардлагад нийцсэн бөгөөд төсөвт нэмэлт ачаалал үүсгэхгүй байна.

- Хуулийн төсөл нь бусад хууль тогтоомжтой харилцан уялдсан байна.

**Тав. Зөвлөмж**

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үр нөлөөний үнэлгээг зохих журмын дагуу хийж гүйцэтгэхэд хуулийн төсөл зорилгодоо хүрэх боломжтой, хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн байх тул хуулийн төслийг хэвээр үлдээх нь зүйтэй байна.

--oOo--



**ЭДИЙН ЗАСАГ,  
ХӨГЖЛИЙН ЯАМ**

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН  
НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ  
ЗАРДЛЫН ТООЦОО**

**2023 он**

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

## НЭГ.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг /цаашид “хуулийн төсөл” гэх/ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан **Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал** /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төслийг хуулийн шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулсан байна. Хуулийн төсөл нь шинэчилсэн найруулгын хэлбэрээр бичигдэж байгаа ба уг хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр болон өмнө гүйцэтгэж байсан үүрэгт шинээр нэмэгдсэн, эсхүл хасагдсан чиг үүргийн хүрээнд үнэлгээг хийнэ.

Хуулийн төсөл нь гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих, хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах, гадаадын хөрөнгө оруулагч этгээд Монгол Улсад хуулийн этгээд байгуулах, бизнесийн үйл ажиллагаа явуулахад үүсэж буй хүндрэл, дарамтыг бууруулах мөн хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрх, үүргийг хуульд тусгах, хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргээс давхардлыг арилгахад чиглэсэн бөгөөд аргачлалд заасны дагуу хуулийн төслийн зохицуулалтаар шинээр орж байгаа чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцсон болно.

Тус хуулийн төсөл батлагдсанаар уг хуулийг хэрэгжүүлэх иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үүсэх зардал, ачааллыг тооцож, үүнийг хялбарчлах, бууруулах талаар санал боловсруулахад энэхүү тайлан чиглэгдэх болно.

## ХОЁР. ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАД ҮҮСЭХ ЗАРДЛЫГ ТООЦСОН БАЙДАЛ

### Зардал тооцсон субъект:

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан болно:

- Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

“Аргачлал”-ын 1.5-д заасны дагуу дараахь 3 этгээдтэй холбогдон гарах зардлыг тооцов.

1. Иргэнд үүсэх зардал;
2. Хуулийн этгээдийн зардал;
3. Төрийн байгууллагын зардал.

### 1. Иргэнд үүсэх зардал

Хуулийн төслийн хүрээнд иргэн гэдэгт хуулийн төслийн 3.1.4 дэх заалтын дагуу “хувь хүн /Монгол Улсын иргэн, Монгол Улсад цагаачлан оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэн болон харьяалалгүй хүн”-ийг багтаан үзсэн болно.

**Дүгнэлт:** Хуулийн төслөөр иргэний хувьд нэмж гүйцэтгэх үүрэг үүсэхгүй тул иргэнд шууд үүсэх зардал байхгүй болно.

### 2. Хуулийн этгээдийн зардал:

Хуулийн төсөл нь одоогийн хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах цаашилбал гадаадын хөрөнгө оруулагчдыг Монгол Улсад хөрөнгө оруулж, бизнесийн үйл ажиллагаа явуулах бололцоог нэмэгдүүлэх зорилготой. Энэ зорилгын хүрээнд боловсруулсан хуулийн төслийн нэмэлт зохицуулалтууд нь

хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд эерэг нөлөөтэй бөгөөд ямар нэгэн илүү үйлдэл, зардал үүсгэхгүй.

**Дүгнэлт:** Хуулийн төслөөр хуулийн этгээдийн хувьд шууд үүсэх зардал байхгүй, харин гадаадын хөрөнгө оруулагчид зардал талаасаа илүү таатай орчин бүрдэж байна.

### **3. Төрийн байгууллагын зардал:**

#### **Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага:**

Хуулийн төсөл батлагдсанаар Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тухайд зарим чиг үүрэг нь Хөрөнгө оруулалт худалдааны газарт шилжсэн тул тус байгууллагад шинээр орон тоо нэмэх, бүтэц өөрчлөх шаардлагагүй байна. Иймд төсөвт ямар нэгэн зардал нэмэгдэхээргүй байна.

#### **Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага:**

Монгол Улсын Их Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 69 дүгээр тогтоолоор Хөрөнгө оруулалт худалдааны газрыг “Төрийн захиргааны байгууллын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-д оруулсан байдаг.

Үүний дагуу Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 37 дугаар тогтоолоор Хөрөнгө оруулалт, худалдааны газрыг байгуулж, орон тооны хязгаарыг 30 байхаар тогтоосон.

Харин одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуульд тус байгууллагын талаар болон түүний чиг үүргийн талаар ямар нэгэн зохицуулалт тусгагдаагүй.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлсон ба уг хуулийн төсөл батлагдсанаар хуульд заасан чиг үүргийг Хөрөнгө оруулалт, худалдааны газар хэрэгжүүлэхээр байна.

Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд "11.1.Хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

11.1.1.хөрөнгө оруулалтыг татах, хадгалах, өргөжүүлэх зэрэг хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн цогц үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх;

11.1.2.хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, мэдээллээр хангах;

11.1.3.хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, өргөтгөх, хадгалахад мэдээлэл, зөвлөгөө өгөх замаар дэмжлэг үзүүлэх;

11.1.4.хөрөнгө оруулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;

11.1.5.хөрөнгө оруулалттай холбоотойгоор төрийн бусад үйлчилгээний талаар зөвлөх болон цахим нэг цонхны үйлчилгээ үзүүлэх;

11.1.6.хөрөнгө оруулалт татахад зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, сонирхогч этгээдийг мэдээллээр хангах;

11.1.7.хөрөнгө оруулалтын орчны чиглэлээр төв банк, төсөв, санхүү, хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, нийгмийн даатгал, бүртгэл, гадаадын иргэн, харьяат, газар, чөлөөт бүс болон шүүхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас хөрөнгө оруулалттай холбоотой статистик мэдээллийг улирал, хагас, бүтэн жилээр гаргуулж, нэгдсэн статистик мэдээллийг гаргах;

11.1.8.хөрөнгө оруулалтын асуудлаарх мэдээллийн санг хөтлөх;

11.1.9.хуульд заасан бусад." гэж заасан байна.

Дээр дурдсан чиг үүргийн дагуу хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах, зорилтот улс, бүс нутаг, эдийн засгийн салбар, тэргүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт татах, зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, төслийн нэгдсэн мэдээллийн сан үүсгэх, төслийн бэлэн байдлыг хангаж чадавхжуулах, төрийн үйлчилгээг үзүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх ба тус газрын байгууллагын зүгээс батлагдсан орон тоо, төсөвтөө багтаан хэрэгжүүлэхээр байх ба төсөв шаардсан нэмэлт ажил, чиг үүрэг хуулийн төсөлд тусгагдаагүй байна.

Тухайлбал, хуулийн төсөлд хөрөнгө оруулалтын тодорхойлолт олгох ажил хасагдсан, тогтворжуулах гэрчилгээ авах, хөрөнгө оруулалтын талаар гомдол гаргах, шийдвэрлэх ажиллагаа цахим хэлбэрээр явагдахаар тусгагдсан байх тул тус ажиллагааг гүйцэтгэх албан хаагчдын ажлын цагийн ачаалал, бичиг хэргийн зардлыг багасгахаар байна.

Иймд хуулийн төсөл батлагдсанаар Хөрөнгө оруулалт, худалдааны газрын чиг үүрэг хуульд тусгагдаж, үйл ажиллагаагаа явуулах эрх зүйн орчин бүрдэж байгаа ба батлагдсан орон тооныхоо хүрээнд үйл ажиллагаагаа явуулах тул төсөвт зардал нэмэгдэхгүй байна.

Мөн түүнчлэн хуулийн төсөлд дээрх хоёр байгууллагаас бусад төрийн байгууллагад шинээр орон тоо нэмэх, нэмэлт санхүүжилт шаардагдах чиг үүрэг тусгагдаагүй байна.

**ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ:**

**Зардлын тооцооны судалгааны үр дүнд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэхтэй холбогдон иргэн, хуулийн этгээд, холбогдох төрийн байгууллагад нэмэлт зардал гарахгүй, төсөвт дарамт учрахгүй нь тогтоогдов.**

---oOo---

## ТАНИЛЦУУЛГА

### *Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулсан тухай*

Хуулийн төсөл боловсруулахад олон нийтийн оролцоог хангах, оролцогч талуудын санал хүсэлтийг авах зорилгоор олон нийтийг хэлэлцүүлгийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу бичгээр болон цахимаар, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг хэлбэрээр зохион байгуулан ажилласан.

1. Хуулийн төслийг монгол, англи хэлээр цахим хуудсанд 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрөөс эхлэн 06 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл буюу 65 хоногийн хугацаанд цахим хуудсанд байршуулж, олон нийтийн саналыг авсан.

Хуулийн төсөлд Олон улсын валютын сан, Дэлхийн банк, Олон улсын санхүүгийн корпораци зэрэг олон улсын байгууллага, Япон Улс, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, гадаадын улсын 2 байгууллага, Монголын Уул Уурхайн Үндэсний Ассоциаци, Америк-Монголын Худалдааны танхим, Монголын бизнесийн зөвлөл, Улаанбаатар Худалдааны Танхим, Австралийн Худалдаа аж үйлдвэрийн танхим, Европ Монголын хамтарсан худалдаа аж үйлдвэрийн танхим, МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитр, Зунхуа нийгэмлэг, Монголын хүнд үйлдвэрийн эрдэс холбоо, “Мобиком Корпораци” ХХК, “Оюу Толгой” ХХК, “Монголжин” ХХК, “М-Си-Эс” групп, “Бадрах Энержи” ХХК, “Монцемент билдинг материалс” ХХК, Хөшигийн хөндийн бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа, “Алисон энд Кейт” ХХК болон иргэдээс ирүүлсэн 600 гаруй саналыг хүлээн авсан.

2. Мөн олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын 120 гаруй байгууллагын 250 орчим төлөөллийг оролцуулан хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлгийг 2 удаа, хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоодын төлөөллүүдтэй 10 гаруй цуврал уулзалтуудыг зохион байгуулан олон нийтийн оролцоог хангаж ажиллалаа.

Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн эхний хэлэлцүүлгийг 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн талаар танилцуулж, панел хэлэлцүүлгийг олон улсын байгууллага, хувийн хэвшил, хөрөнгө оруулагчдын төлөөллийг оролцуулсан хийсэн.

Панел хэлэлцүүлгээр Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчны өнөөгийн нөхцөл, хөрөнгө оруулалт хийх, бизнес эрхлэх боломж, төрөөс үзүүлэх дэмжлэг

хөрөнгө оруулагчдад тулгарч буй хүндрэл бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга замуудын талаар хэлэлцсэн.

Тус хэлэлцүүлэгт олон улсын байгууллага, гадаад улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, Америк-Монголын худалдааны танхим, Монголын бизнесийн зөвлөл, МҮХАҮТ, Улаанбаатар худалдааны танхим, Австрали-Монголын худалдааны танхим, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, Европ-Монголын хамтарсан худалдаа, аж үйлдвэрийн танхим зэрэг мэргэжлийн холбоод, танхимууд, хөрөнгө оруулагчид болон төрийн байгууллагуудын 150 гаруй төлөөлөл оролцсон.

3. Хуулийн төслийн 2 дахь нээлттэй хэлэлцүүлгийг 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд олон нийтээс ирүүлсэн санал болон хөрөнгө оруулагч, мэргэжлийн холбоодын төлөөллүүдтэй хийсэн цуврал уулзалт, хэлэлцүүлгүүдийн үеэр өгсөн санал, хүсэлтийг хуулийн төсөлд тусгасан талаар танилцуулсан.

Хуулийн төсөлд олон улсын байгууллага, хөгжлийн түнш, Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, мэргэжлийн холбоод, бизнесийн зөвлөл, танхимууд, төрийн байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн нийт саналыг 60 хувийг хуулийн төсөлд тусгаж, 20 хувийг тусгаагүй бөгөөд үлдсэн 20 хувь нь хуулийн төслийн талаарх ерөнхий сэтгэгдэл байсан талаар дэлгэрэнгүй танилцуулсан болно.

Хэлэлцүүлэгт оролцогчдын зүгээс Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгсөн олон нийтийн саналуудыг хэрхэн тусгасан талаар эргэн танилцуулж, хөрөнгө оруулагч, бизнесийн байгууллагуудынхаа оролцоог ханган ажиллаж байгааг онцлон тэмдэглэсэн юм.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР**